

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +9
Шөнө -5

УЛС ТӨР

М.ЭНХБОЛД МОПИЯЦ
БАЙГУУЛЖ БАЙГАА ЮУ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ИРГЭД НӨАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ
АВАХЫГ ХҮСЧ БАЙНА ГЭВ

V нүүрт



Дугаарын **60** мөр

Сонгуулийн
солиотой
сурталчилгаа

Б.ДАВАА

Саяхан нөхрийн угас руу нэгэн нэр дэвшигч залгах нь тэр. Ямар нэг улс төрийн хүчинд харьяалагддаггүй, манайхны хэлдэгээр "Саарал" хүмүүсийн тоонд багтдаг бид ч тун их гайхлаа. Гэтэл "Танай дүүрэгт нэр дэвшиж байгаа Б байна. Нэг нутгийн хүмүүс рүүгээ ярьж мэнд мэдэж байгаа юм. Миний төлөө саналаа өгөөрэй. Бас хамаатан садандаа санал болгож өгнө үү" гээд л эелдэг гэгч нь ярилаа. Ийм явдал дөрвөн жилийн өмнө нь ч давтагдаж байсан санагдана. Өмнөх сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуульд нэр дэвшигч мөн л нэг нутаг гэсээр хэсгийн ахлагчийн хамт гэрт хүртэл зочилж, саналаа өгөхийг хичээнгүйлэн хүсч байсан удаатай.

Үргэлжлэл нь III нүүрт

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

18 дахь жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ 15600

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

М.МӨНХБААТАР: В.ПУТИН ЕРӨНХИЙЛӨГЧ МАНАЙ КОМПАНИТАЙ ХУЙВАЛДСАН БОЛЖ ТААРАХ УУ

Б.МАГНАЙ

Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг ОХУ-ын "Ростех" компаниас худалдаж авсан "Монголын зэс" корпорацийн ТУЗ-ийн дарга М.Мөнхбаатартай ярилцлаа. Тэрбээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд анх удаа дэлгэрэнгүй ярилцлага өгч буй нь энэ юм.

"Тантай "Эрдэнэт" үйлдвэрийн хувьцаа тойрсон асуудлаар ярилцах гэсэн юм. Танай компани "Эрдэнэт" үйлдвэртэй хэрхэн холбогдсоноос ярилцлагаа эхлэх үү?"

"Эрдэнэт" үйлдвэрийн шавыг анх 1973 онд тавьсан. Үйлдвэр ашиглалтад орсноос хойш Оросын тал 50, Монголын тал 50 хувийг эзэмшиж ирсэн. Харин 1990-ээд оны эхээр, Д.Бямбасүрэн гуайг Ерөнхий сайд, одоо "Эрдэнэт" үйлдвэрийн ТУЗ-ийн дарга

байгаа Да.Ганболдыг Тэргүүн Шадар сайд байх үед Монгол Улсын Засгийн газархувианэмж 51 болгосон. Сая харин Оросын талын 49 хувийг "Монголын зэс" гэж үндэсний компани худалдаж авснаар 43 жилийн дараа "Эрдэнэт" үйлдвэр 100 хувь Монгол Улсын, монголчуудын мэдэлд ирж байгаа юм. Нэг зүйлийг зориуд онцолж хэлэхэд, Монгол Улсын Засгийн газрын эзэмшиж байсан 51 хувьд огт өөрчлөлт ороогүй, төрийн мэдэлд хэвээрээ байгаа. Харин бид Оросын талын эзэмшиж байсан 49 хувийг худалдаж авсан.

Үргэлжлэл нь IV нүүрт

PC mall. DELL ХААН БАНК



ЛИЗИНГИЙН ХҮҮ: ЖИЛИЙН 8% БОЛМОО

ЗӨВХӨН DELL БРЭНДИЙН НӨҮТБҮҮК

7575-3535 www.pcmall.mn /PCmallOfficial

ХААН банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2258.00	2275.00	ФУНТ	2739.00	2839.00
ЕВРО	2487.00	2557.00	РУБЛЬ	35.00	38.10
ИЕН	21.54	22.13	ЮАНЬ	336.00	340.60

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

УИХ-ын гишүүдэд "цалинтай чөлөө" олгов

УИХ-ын чуулган энэ долоо хоногт товчлосон өдөр, тогтсон цагтаа эхэлсэнгүй дахин хойшиллоо. Учир нь Орон нутгийн сонгууль ойртож буй энэ өдрүүдэд гишүүд хуралдах завгүй байна. Уг нь өнгөрсөн даваа гарагт УИХ дахь намын бүлгүүд хуралдаж, тухайн долоо хоногийн асуудлаа авч хэлэлцэх ёстой байдаг. Гэтэл аль ч бүлэг нь хуралдсангүй. Учир нь бүлгийн гишүүд орон нутгийн сонгууль дөхсөнгүй холбоотой хөдөө ажиллаж байгаа тул ирц нь бүрдээгүй гэх шалтгаанаар хойшлогдсон. Тэгвэл очигдөр УИХ-ын Төсвийн байнгын хороо хуралдаж, 2017 оны төсвийн төслийн талаар хэлэлцэхээр товчлогдсон байлаа.

Гэвч ирц хүрэхгүй гэсэн шалтгаанаар тус Байнгын хорооны хуралдаан мөн л тодорхойгүй хугацаагаар хойшлогджихлоо. Ажлаа хийхгүй алга болсон гишүүдээ УИХ-ын дарга "цалинтай чөлөө" олгох шийдвэр гаргажээ. Тодруулбал, Монгол Улсын 2017 оны төсвийн төслийг иргэдэд тайлбарлан таниулах, төсөлтэй холбоотой санал хүсэлтийг сонсох зорилгоор УИХ-ын намын ээлжит чуулганыг аравдугаар сарын 11-18-ны өдрүүдэд түр завсарлуулах захирамжид УИХ-ын дарга М.Энхболд очигдөр гарын үсэг зурсан байна. Тиймээс чуулган аравдугаар сарын 20-ны өдрөөс тогтсон хуваарь, горимын дагуу үргэлжлэхээр болж байна.



Ж.ОТГОН

ШӨХТГ-ын дарга асан О.Магнай Монгол Ардын нам сонгуульд ялснаас хойшхи 100 хоногт ямар ажлууд хийсэн талаар тайлан бүхий ном гаргасан талаар мэдээлэл хийлээ. Уг тайлангаа тэрбээр хараат бус хэмээн тодотгосон байна. "Засгийн газар 100 хоногт" тайланд МАН-ын Засгийн газар ажлаа авснаас хойш юу хийсэн тухай баримтуудыг тусгажээ. Тэрбээр "Энэ бол цэвэр хараат бус, иргэний байр сууринаас нэгтгэсэн тайлан гэдгийг та бүхэн ойлгоорой. Тайлан МАН юу амлав, ураг төрлийн томилгоо, 100 хоногт ямар ажил хийв гэсэн гурван хэсгээс бүрдэж байгаа юм байна. Энэ талаар О.Магнай "МАН сонгуульд ялснаас хойш 100 хоног өнгөрсөн. Энэ хугацаанд тэд юу хийв, улс орныг хааш нь чиглүүлж явна, иргэд юу хүлээж байсныг нэгтгэн тайлан гаргасан. МАН-ын дарга М.Энхболд зөвхөн ах дүү амраг садныхаа 20 гаруй хүнийг томилсон нь улс төрийн хүчин мөн үү гэдэгт эргэлзэхээр байдал үүсгэлээ. Эсвэл нэг хүн дарангуйлал тогтоох гэж ах дүү амраг саднаараа мөниац байгуулж байгаа юм уу. Мөниац бол зөвхөн гэр бүл дээр тогтдог. Мөн МАН-аас томилгосон удирдах албан тушаалтнуудын жагсаалтыг гаргасан. Нэр бүхий гишүүд дарга нарын ойр дотны хүмүүсээс гадна Монголын морин спорт уяачдын холбоо холбоогоороо дарга болсон. Холбооны дэд тэргүүн нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, дэд ерөнхийлөгч нь Барилга хот байгуулалтын яамны дэд сайд болсон. Нийслэлийн морин спорт уяачдын холбооны дарга, тэргүүлэгч нь ХХААХУ-ийн яамны газрын дарга нар болжгоосон байна. Энэ юуг харуулж байна гэвэл өнгөрсөн хугацаанд хийсэн бүх томилгоо ах дүү амраг садны сүлжээгээр буюу өндөр албан тушаалд томилсон томилгооны 70 хувь нь МАН-ын удирдах албан тушаалтай ямар нэг байдлаар холбогдож байна. Ийм л төр 100 хоногийн хугацаанд бүрдэж бий болсон байна" гэлээ.

ММ-ийн тодруулга

Б.Чойжилсүрэн: Олон улсын валютын сантай хөтөлбөр хэрэгжүүлэхээр урьдчилсан хэлэлцээ явуулж байна

"Стэнд бай" хөтөлбөрт хамрагдах саналаа тавихаар Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамт АНУ-ыг зориод ирсэн. Тэгвэл ямар шийдвэр гаргаад ирсэн талаар Сангийн сайд Б.Чойжилсүрэнгээс тодрууллаа.

"Стэнд бай" хөтөлбөрт хамрагдах саналаа тавихаар АНУ-ыг зориод ирлээ. Ямар шийдвэр гарсан талаар тодруулаач?

ТОМИЛГООНУУД:

- УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболдын хүү Э.Анар нь Монголбанкны төлбөр тооцоо бүртгэлийн газрын захирлаар томилгодог.
- УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболдын төрөл садан А.Ундраа УИХ-ын гишүүн болов.
- УИХ-ын гишүүн Н.Энхболдын хүү А.Цогцэцэг Эрүүл мэндийн сайдаар томилгодог.
- Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын дүү Ж.Эрдэнэтөгс Сэлэнгэ аймгийн ОНӨУГ-ын даргаар томилгодог.
- МАН-ын дарга асан Сү.Батболдын хүү Б.Баттүшиг нь Монголбанкны бодлогын зөвлөлийн гишүүнээр томилгодог.
- МАН-ын дарга асан Сү.Батболдын эхнэрийн дүү Б.Асралт Гаалийн ерөнхий газрын даргаар томилгодог.
- Шадар сайд У.Хуралсүхийн дүү У.Отгонбаяр Барилга хот байгуулалтын яамны газрын даргаар томилгодог.
- Шадар сайд У.Хуралсүхийн төрсөн ахын хүү Г.Гантулга Зам тээврийн яамны газрын даргаар томилгодог.
- Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтын дүү С.Тунгалагтамир нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Д.Сарангэрэлийн хүү Улам-Өрнөх Худалдан авах ажиллагааны газрын албаны даргаар томилгодог.
- И.Сангийн сайд асан Т.Очирхүүгийн хүү О.Эрдэмбилэг Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилгодог.
- УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн хүү Н.Анхбаяр нь Гадаад харилцааны яамны Төрийн Захиргаа Удирдлагын Газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Д.Лүндэжванцагийн дүү Д.Баярсайхан нь Төрийн банкны захирлаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Т.Аюурайханы эгч Т.Саран нь Нийгмийн Даатгалын Ерөнхий газрын дэд даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Ц.Гарамжавын хүргэн нь Оюутолгой ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилгодог.
- УИХ-ын гишүүн Б.Саранчимэгийн нөхөр нь "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Б.Оюунчимэгийн дүү Б.Эрхэмзаяа нь "Эрдэнэ Таван Толгой" ХК-ийн тээвэр, ложистик хариуцсан захирлаар томилгодог.
- УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболдын гэр бүлийн найз Г.Мөнхбаяр нь Барилга хот байгуулалтын сайдаар томилгодог.
- УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболдын гэр бүлийн найз Л.Бямбасүрэн нь Эрүүл мэндийн дэд сайдаар томилгодог.
- МАН-ын дарга М.Энхболдын тэргүүдэд Монголын морин спорт уяачдын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, биеийн тамирын багш П.Сэргэлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилгодог.
- МАН-ын дарга М.Энхболдын тэргүүдэд Монголын морин спорт уяачдын холбооны дэд ерөнхийлөгч Ш.Лхамсүрэн Барилга, хот байгуулалтын дэд сайдаар томилгодог.
- Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд С.Бямбацогтын туслах З.Мэндсайхан нь Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргаар томилгодог.
- Ерөнхий сайд агсан П.Жасрайн зээ охин Ариунзаяа Үндэсний Статистикийн Газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Д.Сумъяабазарын гэр бүлийн эзэмшлийн "Үндэсний хөрөнгө оруулалтын банк"-ны захирал Б.Баярсайхан нь Үндэсний хөгжлийн газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Н.Номтойбаярын гэр бүлийн эзэмшлийн "МАК" компанийн дэд ерөнхийлөгч Б.Нямдаваа нь Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргаар томилгодог.
- Су.Батболдын туслах нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Ж.Энхбаярын эхнэрийн дүү С.Мөнгөнчимэг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэд сайдаар томилгодог.
- Морин спорт уяачдын холбооны гишүүн, манлай уяач Даваахүүгийн хүү Д.Баянбат нь нийслэлийн хөдөө аж ахуйн газрын даргаар томилгодог.
- Нийслэлийн Морин спорт уяачдын холбооны дарга н.Мөнхбаясгалан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн захиргаа, удирдлагын газрын даргаар томилгодог.
- Морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч Ц.Баянжаргал Хүнс, хөдөө аж ахуйн яамны газрын даргаар томилгодог.
- УИХ-ын гишүүн Б.Саранчимэгийн дүү нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн даргаар томилгодог.
- МАН-ын сонгуулийн сурталчилгааны менежер сэтгүүлч Б.Баярсайхан Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилгодог бол, түүний нөхөр МАН-ын сонгуулийн сурталчилгааны менежер П.Байрмагнай Гадаад Харилцааны Яамны газрын даргаар томилгодог.

М.ЭНХБОЛД МОНИАЦ БАЙГУУЛЖ БАЙГАА ЮУ



Гэрэл зургийн Г.АРГУУЖИН

Энэ бүх тохмилгооноос үзвэл МАН-ын амлалт энэ хугацаанд 100 хувь эсрэгээрээ болж байна гэдгийг тэрбээр онцолж байлаа. Учир нь МАН-ын Мөрийн хөтөлбөрийн 4.2.7-д Төрийн байгууллагыг удирдаж байгаа хүмүүс ах дүү, хамаатан саднаа ажилд авахыг хориглоно. 4.2.8-д Төрийн албанд шат ахуулан албан тушаал дэвшүүлэх Мерит тогтолцоог хэвшүүлэн гэсэн байгаа юм. Энэ талаар тэрбээр "Мерит тогтолцоо бол ажилдаа байгуулсан гавьяагаараа албан тушаал дэвчдэг зарчим байдаг. Гэвч бодит байдал дээр юу болсныг хүмүүс мэднэ. Монголыг ирэх дөрвөн жил удирдах баг тэр чигтээ МАН-ын удирдах албан тушаалтнуудын ах дүү амраг садан гэр бүлийн баг байх юм гэдгийг 100 хоногийн хугацаанд харлаа. Ах дүү, амраг садан нийлээд төр удирдана гэдэг бол нэгийгээ шүүмжлэхгүй гэсэн үг. Буруу зүйл хийсэн бол алдааных нь хажуугаар чимээгүй өнгөрнө. Жирийн иргэн хүн улс эх орондоо мөрөөдлөө биелүүлэх боломжгүй болж байна. Яаманд мэргэжилтэн хийж байгаа олон залууст мөрөөдөл бий. Тэдгээр чадварлаг залуусын мөрөөдөл биелэхгүй байх суурийг МАН тавилаа.

Ажил хийдэг биш зогсоодог Засгийн газар байгуулагдсан

Засгийн газар 100 хоногийн тухайд тэрбээр "Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг судлаад үзэхэд бодитой шийдвэр гаргасангүй. Ядаж 100 хоногийн дотор зөв чигтээ олох ёстой. Нийгэмд хамгийн их тулгамдсан асуудал бол авлигатай тэмцэх. Авлига албан тушаалын гэмт хэрэг бүх шатандаа эх захаа алдсан учраас 100 хоногийн хугацаанд МАН авлигатай тэмцэхээ хэрхэн эхлэхийг ард түмэн хүлээж байсан. Харамсалтай нь юу ч хийсэнгүй. Эдийн засаг хямралаас гэсэн асуудлыг МАН сонгуулийн өмнөх нэг жилд хангалттай ярьсан. Тиймээс Монгол Улсыг хямралаас гаргах төлөвлөгөөгөө МАН танилцуулсангүй. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хямралаас гаргах төлөвлөгөө баталж чадалгүй гурван сарыг ардаа орхилоо. Өндөр настан, залуучуудтай холбоотой нэлээд олон ажлыг гацаалаа. Засгийн газрын хуралдаан болгон дээр 2-3 ажлыг МАН-ын Засгийн газар зогсоосон гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Ажил хийдэг биш зогсоодог Засгийн газар байгуулагдсан гэж дүгнэхэд буруудахгүй. 1990 онд Монголын

ард түмэн хувьсгал хийсний үр дүн нь 1992 онд батлагдсан Үндсэн хууль юм. Гэтэл коммунист удирдагчийн 100 насны төрсөн өдрийг Монгол орон даяар татвар төлөгчдийн мөнгөөр тэмдэглэлээ. Гэхдээ хувь хүнийх нь тухай ярих шаардлагагүй. Ардчилсан нийгэм байгуулж байгаа улсад өнгөрсөн нийгэм рүү сангалзаж ухарч байгаа энэ үйл явдал Монголчуудыг оюун санааны хувьд хойш нь алхуулсан үйл явдал болсон гэж дүгнэж байна. Ардчилал, хүний эрх эрх чөлөөнд хандах хандлага жаахан сулрах юм бол нэг дарангуйлагч гараад ирнэ. Тийм хүний төрсөн өдрийг ингэж тэмдэглэж байгаа нь дарангуйлагч төрөх эхлэл болж байна. Үүнийг зөвшөөрч болохгүй" гэлээ.

Энэ үеэр түүнээс зарим асуултад хариулт авлаа.

«Ер нь ялсан намын дарга Ерөнхий сайд болдог. Энэ удаад ч тэгсэнгүй. Үүнийг та юу гэж харж байгаа вэ?»

«Урьд нь тоглоомын дарга гэж ярьдаг байсан бол одоо тоглоомын Ерөнхий сайдтай боллоо. Парламентын засаглалтай аль ч улс оронд ялсан намын дарга Ерөнхий сайд болоод эрсдлээ үүрээд явдаг бичигдээгүй дүрэм журам эсэүй байдаг. Гэтэл өөрийнхөө хүнийг Ерөнхий сайд болгоод ард нь сууж байдаг шинэ жишгийг тогтоож байна. Монголын ард түмэн ямар ч сонголт хийгээгүй байхад 2017 онд хэн Ерөнхийлөгч болох нь тодорхой боллоо гэж яригдаж байна. Иймэрхүү байдлаар Монгол орныг эзэлж, жирийн иргэдийг түрэмгийлж байгаа байдлыг зүгээр хараад сууж, хүлээн зөвшөөрч болохгүй. Бэлэн мөнгөний эргэлтийн 60-70 хувь, экспортолж байгаа түүхийн эдийн 50-иас дээш хувь нь нэг бүлэглэлийн гарт орчихлоо. Бүлэглэлийн тогтолцоо бий болж Монгол Улс байхгүй болох тийшээ явж байна.

«Ялсан намын дарга Ерөнхий сайд болдог жишгийг АН эрх барьж байхдаа тогтоосон шүү дээ?»

«АН олонхийн суудал аваад Н.Алтанхуяг дарга Ерөнхий сайд болсон. Би Ч.Сайханбилэгийн Засгийн газрын эсрэг байсан. Одоо ч гэсэн МАН шударга ёсыг тогтоох гэж сонгуульд орж байгаа бол хариуцагаа тооцосой гэж боддог. Ч.Сайханбилэг, С.Баярцогт нар нийлээд Монгол Улсаар яаж тогтоосныг бүгд мэднэ. Тэр үед яах гэж Засгийн газрыг огцруулсан нь өнөөдөр тодорхой болж байна. Зүгээр хоёр хүн биш ардаа том бүлэглэл байсан юм байна. Одоо энэ бүхнээс гарах нэг л гарц байна. МАН, АН гэлтгүй улстөрийн намуудыг бүгдийг тараагаад дахиж шинээр бүртгээд цааш явах юм бол Монголчууд хожиж болно. Монгол Улсын төлөө АН, МАН байдаг юм уу, эсвэл энэ хоёр намын төлөө Монгол байдаг юм уу гэдэг асуултад хариу авах ёстой. Улстөрийн намын төлөвшил 1990 оноос хойш буруу явсан. Хэлтгий зүйл дээр барьсан байшингаа заавал нурааж байж шинээр эхлэх үү, замаас нь засаад явах уу гэдэг сонголт ард түмний өмнө байгааг мартаж болохгүй.

«бай» хөтөлбөр хэрэгжүүлэхгүй гэвэл мөнгө босгох гарц байгаа вэ?»

«Энэ талаар холбогдох хэлэлцээ явж байна. Эцсийн шийдвэр гаргаагүй. Эдийн засгийн хямралыг даван туулах төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар оруулж, эцэслэн баталсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулаад түүний дараа УИХ-д оруулаа.

«Бондыг бонд гаргаж өрөө төлөхөөс аргагүй гэсэн. Энэ байр суурь хэвээрээ байгаа юу?»

«Дахиж бондыг бонд гаргаж

санхүүжүүлэхээс өөр шууд гаргаад өгөх хэмжээний эх үүсвэр байхгүй.

«Санхүүгийн өөр эх үүсвэр байхгүй гэдгийг олон гишүүд хэлсэн. Гэхдээ өөр эх үүсвэр олох талаар ярилцаж байна уу?»

«Холбогдох санхүүгийн байгууллагууд, гадаад улс орнуудтай ярилцаж байна. Арилжааны нөхцөлтэй зээлүүд Монгол Улсыг өрийн дарамтад оруулж байгаа учраас магадгүй хөгжлийн зээлүүдийг бусад эх үүсвэрээс хайхаас аргагүй болж байгаа.

ҮЗЭЛ БОДОЛ

ЧАЛКОГИЙН ӨР БАРАГДСАН ЦАГТ НҮҮРСНИЙ ҮНИЙГ ЧӨЛӨӨЛӨХ БОЛОМЖ НЭЭГДЭНЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Монгол Улс нүүрсээр баян орны хувьд эдийн засгийн хямралыг нүүрсний экспорт дээрээ дөрөөлөөд зовлонгүйгээр давж гарах боломж бололцоо байгаа юм, уг нь. Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ өмнөх жилүүдийг бодвол боломжийн хэмжээнд өсч, 200 ам.доллар давчихаад байхад манай коксжсон тонн нүүрсний үнэ ердөө 27 ам.доллар байгаа нь дэндүү харамсмаар зүйл. Монголчууд өртэй дээр нь валютын хомсдолтойн гайгаар австраличууд шиг тонн нүүрсээ 200 ам. доллар гээд зогсч чадахгүй байгаа юм. Өр гэхээр хэн бүхний тархинд Чалкогийн өр харван орж байгаа байх. Үнэндээ тийм. “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2011 оны долдугаар сарын 26-нд Хятадын

төрийн өмчит Чалко компанитай байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний урьдчилгаа төлбөр болох 350 сая ам.долларын өрийн асуудал Монголын эдийн засагт чөдөр тушаа болоод байгаа хэрэг. Тэрхүү гэрээг үзэглэсэн хүмүүс нь одоогийн эрх баригч МАН-ын гишүүд. Тонн тутмыг нь 70 ам.доллараар зарж борлуулахаар хийсэн гэрээг цуцлах шийдвэр гаргаж, нүүрсний үнийг өнөөдрийн төвшинд хүргэсэн нь харин АН-ынхан. Нүүрсний үнийн хоромхон зуурын өсөлтөд эрдэж, “Өндөр үнэтэй нүүрсийг хямдаар өглөө” хэмээн гэрээг зогсоосон эрхмүүд нүүрсний үнэ буурвал яах вэ гэдгийг тооцоолоогүйгээс Монгол Улс өнөөдөр тонн коксжсон нүүрсээ 27-хон ам.доллараар царайчлан байж экспортлож буй.

Байгалийн баялгаа барьцаалан

...Статистикаас харахад, нүүрсний олборлолт, экспорт урьд жилүүдээс өсчээ. Энэ оны аравдугаар сарын 1-ний өдрийн байдлаар Монгол Улс нийтдээ 19 сая тонн нүүрс олборлож борлуулснаас 16 сая тонныг нь экспортод гаргасан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, нүүрсний олборлолт харьцангуй өсөлттэй гарсан гэсэн үг...

байж авсан тэр их мөнгийг тухайн үеийн эрх баригчид 2012 оны УИХ-ын сонгуулийн өмнөхөн Хүний Хөгжлийн Сангаар дамжуулан халамж нэрийн дор салхинд хийсгэж орхисон. Цаг хугацаа явсаар, бид ч өөдлөхгүй өрөө төлсөөр. Авсан нь үнэн юм хойно, төлөх нь ч бас үнэн байж таарна. Ямартай ч өнөөгийн байдлаар 350 сая ам, доллараас төлсөөр 96 сая ам.доллар үлджээ. Эдийн засгийн хямрал нүүрлэсэн энэ цаг үед чамлахааргүй амжилт. Гэхдээ эндээс нэг зүйл харуусал, эргэлзээ хоёрыг зэрэг төрүүлээд байгаа юм. Энэ нь Хятадын дотоодын коксжих нүүрсний үнэ он гарсаар 43 хувь өссөн байхад Эрдэнэс Таван толгой ХК-ий Зүүн Цанхийн коксжих нүүрсний үнэ 36 хувь өссөн явдал. Уг өсөлтөд тээврийн болон бусад зардал ороогүй гэж байгаа. Тэгэхээр зөрүү нь долоон ам.доллар байгаа биз. Эл асуултад хариулах албан салгааны асуудал коммунист суббогтник адил үргэлжилж

байхад ажлаа өгөөд явах гэж байгаа мэргэжилтэнд нүүрсний үнэ өснөө, буурна уу юуны хамаа байх билээ. Гэвч холбогдох яам хийгээд “Эрдэнэс таван толгой”-нхон тэгж байгаад нэг тайлбар өгөх байх. Харин нүүрсний салбарын шинжээчдийн үзэж буйгаар “Эрдэнэс Таван толгой” ХК Хятадын төрийн өмчит Чалко компаний өрийг бүрэн барагдуулсан цагт Тавантолгойн ордын Зүүн Цанхийн нүүрсний үнийг чөлөөлөх боломж нээгдэх төдийгүй Зүүн Цанхийн нүүрсний борлуулалтын 100 хувь нь бэлэн мөнгөөр арилжаалагдах нөхцөл бүрдэх аж. Өөнд идэгдэж яваа манай улсын хувьд энэ бол алдаж болохгүй боломж байж мэдэх юм. Тиймээс урд хөршид өргүй, нүүрс экспортлогч МАК гэх мэтийн компаниуд дэлхийн зах зээл дэх үнийн өсөлтийг ашиглан хүссэн үнээрээ борлуулна гээд зүтгэчихэд болохгүй зүйлгүй мэт санагдана. Тэр байтугай “Эрдэнэс-Таван толгой” ХК-д ч уг нь ийм боломж буй. Тодруулж хэлбэл, Зүүн Цанхиас олборлосон нүүрсээрээ Чалкогийн өрийг барагдуулахын зэрэгцээ Баруун Цанхийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар тонн тутамд долоон ам.долларын алдагдал хүлээх бус тийм хэмжээний цэвэр ашигтай ажиллах боломж бүрдэнэ. Ингэснээр валютын урсгал, улсын төсөвт төвлөрөх татварын орлогын хэмжээ нэмэгдээд зогсохгүй өр төлж дууссан тэр өдрөөс Зүүн Цанхийн борлуулалтын орлого нь 100 хувь бэлнээр Монгол Улсад орж ирэх нөхцөл бүрдэж, эдийн засаг тэр хэрээр сэргэхэд нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Статистикаас харахад, нүүрсний олборлолт, экспорт урьд жилүүдээс өсчээ. Энэ оны аравдугаар сарын 1-ний өдрийн байдлаар Монгол Улс нийтдээ 19 сая тонн нүүрс олборлож борлуулснаас 16 сая тонныг нь экспортод гаргасан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, нүүрсний олборлолт харьцангуй өсөлттэй гарсан гэсэн үг. Монгол Улс жилийн өмнө, 2015 онд ердөө 15 орчим сая тонн нүүрс олборлосон байдаг. Харамсалтай нь олборлолтын хэмжээ нэмэгдсэн ч ашиг нь ердөө ч өссөнгүй. Зүүн Цанхийн коксжсон нүүрсний үнэ уурхайн аман дээрээ 27 ам.доллараас өсөхгүй байгаа нь ашиг, орлогод нөлөөлсөн нь дамжиггүй. “Зүүн Цанхийн ханшийг хатуу барьж буй хятадуудын бодлого Тавантолгой орчмын хувийн компаниудыг ч нэрвэж байна” хэмээн дуу алдах захирлуудын

үг үнэний ортой. Урд хөрш нүүрэн дээрээ Монгол Улсад эдийн засгийн зээл тусламж олгоод байгаа мэт дур эмгэж цаанаа нүүрсний үнийг өсгөхгүй байх сонирхолтой байхыг ч үгүйсгэх аргагүй. Хятадын гангийн үйлдвэр Монголын коксжих нүүрсний цорын ганц зах зээл хэмээхэд буруудах зүйлгүй. Их гүрний гангын үйлдвэрлэлийн бодлого хааш эргэхээс бидний хувь заяа зарим талаар шалтгаалах болчихоод байгаа нь ч нуух зүйл биш. Хятад улс 2008 оны санхүүгийн хямралыг давж гарсан арга зам нь тун энгийн. Бүхий л нөөц бололцоог дотооддоо ашигласан. Тодруулж хэлбэл, дэд бүтцийн салбартаа ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийн төмөр зам шинээр тавьж, зам гүүрийн олон олон бүтээн байгуулалтад зарцуулсан нь амжилт авчирсан. Энэ нь ч хил залгаа орших Монгол Улсад эерэгээр нөлөөлсөн. Үүнийг бид нүүрсний экспортын оргил жил ч гэж тэмдэглэх болж. Харин энэ удаагийн хямрал 2011 оны дундаас Еврогийн бүсийн өрийн асуудлаас үүссэн учраас Хятад улс дээрхийн адил дотоодын хөрөнгө оруулалтаа хэд дахин нэмэгдүүлж, гангийн үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээг ихэсгэх эсэх нь одоогоор тодорхой бус байгаа. Тиймээс коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ ойрын үед нэмэгдэхгүй байх талтай. Гэхдээ Монгол Улсад боломжууд цаг ямагт байсаар ирсэн нь бурхны хишиг.

Монголын нүүрсний үнэ далайн замаар тээвэрлэгдэх австрайн нүүрснээс хямд тул Монголын нүүрсний борлуулалт тэр хэрээр нэмэгдэж мэднэ. Гэвч сайн юманд садаа мундахгүй гэгчээр замын дэд бүтцийн асуудлаас болж, Монгол Улс байгаа боломжоо зуун хувь ашиглаж чадахгүй үлдэж мэдэхээр нөхцөл байдалд аж төрж буй. Энэ нь эдүгээ ашиглаж байгаа дэд бүтэц экспортын нүүрсний тээвэрлэлтийн ачааллыг даахгүйд хүрч байгаа талаархи мэдээлэл өдөр бүр шахам хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа. Өмнийн говьд тавигдах төмөр зам яригдсаар тав дахь жил рүүгээ орох нь. Холбогдох яамны сайд, дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг Холбогдод ажиллаад ирсэн дуулдсан. Ямартай ч тэрбээр төмөр замын тээврийн салбарт томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр 2017 онд Хөт-Бичигтийн чиглэлийн 222 км зам, “Шивээхүрэн-Сэхэ” боомтын 13 км, Эрдэнэт-ооотын чиглэлийн 547 км төмөр замын барилгын ажлыг 2020 онд дуусгахаар төлөвлөж байгаагаа онцолжээ. Эцэст нь тэмдэглэхэд, популизмаар ташуур хийсэн төрийн түшээд, маргаашийн уушгийг харах тэнхээгүй дарга нарын гайгаар Чалкогийн өрийг төлж дуусаагүй өнөөдөртэй золголоо. Хөршийн ашиг сонирхол бус Монгол Улсын эрх ашгийг дээгүүр тавьдаг төрийн түшээдтэй болсон цагт л Монголын нүүрс үнэд хүрэх биз ээ.

Дугаарын 60 мөр

Сонгуулийн солиотой сурталчилгаа

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Харин сонгууль өнгөрөөд л нэг нутгийн биднийгээ мартсан гэдэг хилсдэхгүй. Сонгууль бүрээр л энэ мэт дүр зураг хөвөрнө. Эдүгээ арга нь бүр нарийсч байх шиг. Нэг нутаг уснаас гаралтай хүмүүсийнхээ утасны дугаарыг тэд ядах юмгүй олдог болжээ.

Үүнээс өөр ч жишээ байна. Сошиал сүлжээ эрчимтэй хөгжиж буй энэ үед янз бүрийн групп, бүлгэм хэн дуртай нь үүсгэх болсон. Энэ жишгийн дагуу манай сумынхан ч албан ёсны групптэй болов. Тэгтэл саяхан нөгөө группт маань зарын шинжтэй нэгэн пост нийтлэгдсэн байх нь тэр. Түүнд “Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөгчийн сонгуульд манай сумаас хоёр хүн нэр дэвшиж байна. Энэ дүүрэгт ажиллаж, амьдарч буй нутгийн ахан дүүс минь саналаа өгөөрэй” гэх тайлбартайгаа зураг хөргийг нь нийтэлсэн байлаа. Энэ мэтээр жалга довны үзэл сонгуулийн үеэр бүр хүчтэй эрчимжиж эхлэв. Нөгөөтэйгүүр, өнгөрсөн УИХ-ын сонгуулиас хойш Хан-Уулынханд нэгэн содон сурталчилгаа бий болчихоод байгаа. Автобусны буудлын хажууд “Азжаргал гэгч хүний сонгуулийн сурталчилгаанд ажиллаж буй хүмүүс уриа лоозонгоо барьж, орилолдон олны анхаарлыг татахыг хичээж байсан. Тэгвэл саяхнаас мөн л нэг намын нэр дэвшигчийн сонгуулийн пиарчид автобусны буудал бараадан зогсч харагдах болов. Намрын сэрүү унасан энэ үед тэд хэрэндээ дулаахан хувцаслаж, нөгөө л нэр дэвшигчийнхээ постерыг барьж орилолдон олны анхаарлыг татахыг хичээж явна. Тэдний автобусны цонхоор харсан зарим нь “Энэ хэдийг хар хүйтэнд яах нь вэ. Ингэж зогсоогоод хөөрхийг” гээд л өрөвдөх юм. Магадгүй сонгуулийн өрөвдүүлэх тактик байж ч мэднэ. Гэхдээ автозамаар өнгөрсөн бүхэн тэрхүү нэр дэвшигчийн тойрогт харьяалагдах нь юу л бол. Өнгөргөч парламентын сонгуульд ажиллан туршлага хуримтлуулсан тэд эдүгээ орон нутгийн сонгуулийн сурталчилгаанд өнөөх аргаа дахин ашиглаж буй нь энэ бололтой. Ер нь ч тэгээд сонгуулийн нэг сайн тал нь ажилгүйчүүд, оюутнууд цөөхөн ч гэсэн хэдэн төгрөгтэй болдог. Ингэж ажиллахын тулд зарим оюутнууд хичээлээ тасалж, зарим нь ойр дотны хэн нэгэн нас барсан гэх мэт хүн итгэхийн аргагүй шалтгаг тоочин чөлөө авч сурталчилгаанд ажиллаж эхэлсэн сурагтай. Тэр бүү хэл, зарим их дээд сургуулийн удирдлагууд албан ёсоор оюутнуудаа эрх баригч намын сурталчилгаанд дайчилж эхэлсэн гэнэ билээ. Сургуулийнхаа удирдлагуудын захиасаар нэр дэвшигчийн сурталчилгаанд дайчлагдсан оюутнуудын шагнал нь “100 А” гэх дүн аж. Ерөнхийдөө улирлын эцэс болох үед сурлага тааруу оюутан гэнэт цоорч, онц төгсвөл гайхаад байх зүйлгүй гэсэн үг. Энэ мэтээр сонгуулийн солиотой гэмээр сурталчилгааны хэлбэрүүдийг нэг нэгэнгүй бичвэл цаг, цаас ч хүрэлцэхгүй нь.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын гишүүн Л.Болд

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Энэ бол нэг хүний хувьцааг нөгөө нь худалдаж авсан, санхүүгийн зах зээл дээр өдөр бүр л болдог энгийн процесс.

-Гол нь Монгол Улсын Засгийн газрын өмнүүр ороод 49 хувийн хувьцааг авчихсан юм биш үү?

-Улс орны өнөөгийн эдийн засгийн байдал, нөөц бололцоог харахад, 49 хувиа худалдаж авна гэдэг нь эргэлзээтэй байна. Ер нь одоо байгаа 51 хувиа нэмэгдүүлж 100 хувь болгоно гэдэг нь аль ч төр, засгийн үеийн бодлого биш байлгүй дээ. Засгийн газар хоорондын гэрээ болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр Оросын тал 49 хувиа худалдажавахыг эхлээд Монгол Улсын Засгийн газарт санал болгоно. Хэрвээ Монгол Улсын Засгийн газар худалдаж авахгүй гэвэл гуравдагч этгээдэд санал болгох ёстой. Энэ бүх процесс болсны дараа бид хувьцаа худалдаж авах өрсөлдөөнд оролцох эрхтэй болсон. Түүнээс бус, Монгол Улсын Засгийн газар худалдаж авах, эс саналаа илэрхийлээгүй байхад, эсвэл Засгийн газар худалдаж авна гээд байхад бид өмнүүр нь



М.МӨНХБААТАР: В.ПУТИН ЕРӨНХИЙЛӨГЧ МАНАЙ КОМПАНИТАЙ ХУЙВАЛДСАН БОЛЖ ТААРАХ УУ

ороогүй. Хууль эрх зүйн хувьд тийм боломж ч байхгүй. Манай Улсын Засгийн газар худалдаж авахгүй гэдэг байр сууриа илэрхийлсэн, тэрнийх нь дараа Хятадын болон Казахстаны компаниудтай хамт манай компани хувьцаа худалдаж авах өрсөлдөөнд оролцсон. Ер нь “Эрдэнэт”-ийн 49 хувийг тойрсон үйл явдал дээр заавал буруутан гаргаж ирэх гээд байгаа бол миний бодлоор тэр нь хувьцаагаа зарсан Оросын тал. Хүн өмчөө зарах, үгүй нь өөрийн л мэдэх хэрэг. Тэр байтугай, хэнд зарахаа өмчийн эзэн мэддэг. Энгийн амьдрал дээр ч ийм дүрэм үйлчилдэг. Хувьцаагаа зарлаа гэж оросуудыг буруутгавал бид л инээдтэй харагдана.

Би Засгийн газрыг төлөөлж ярих эрхтэй хүн биш. Гэхдээ миний бодлоор зургадугаар сард манай улсад улс төрийн сонгууль болж байсан, Засгийн газар мөнгөгүй, санхүүгийн зах зээл дээрээс өндөр хүүтэй мөнгө зээлж авч байсан үе. Тэгээд ч нэгэнт 51 хувийн эрх мэдэл, хяналт нь хэвээр байхад нэмж 49 хувийг худалдаж авч, “Эрдэнэт”-ийн шахааны бизнесийн талбайг томруулах шаардлага байгаагүй байх. Хэрвээ Засгийн газар 49 хувийг нэмж худалдаж авсан бол “Эрдэнэт”-ийн шахаа хийх боломж 49 хувь нэмэгдэх, үйл ажиллагааны ашиг нь магадгүй өнөөдрийнхөөс 49 хувиар унах байсан байж ч болох юм. Монгол Улсын төрд өнөөдөр 51 хувиас илүү, бүр 100 хувийн өмчлөлтэй хэрнээ эзэмшиж байгаа хувьцааны хаахэмжээтэй тэнцэхээргүй ашигтай ажилладаг компани олон бий шүү дээ. Энэ тохиолдолд, өөрөөр хэлбэл, төр авахгүй гэж байгаа тохиолдолд өрсөлдөөнд ороод “Эрдэнэт”-ийн 49 хувийг Монголдоо аваад ирсний төлөө хувийн хэвшлээ буруутгах нь дэлхийд Монголыг л муухай харагдуулна. Ер нь “Эрдэнэт” үйлдвэрийн хувьцаа худалдан авалт тойрсон энэ үйл явдалд төр ингэж хэт оролцох нь хөрөнгө оруулалтыг үргээнэ. Гаднынхан энэ үйл явдлыг анхааралтай ажиглаж байгаа. Гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөдөг Монгол Улс дотоодын хөрөнгө оруулагчдаа ч шахдаг, олон улсын зах зээл дээрээс хувьцаа худалдаж аваад, ирэхээр төр нь дээрэмдээд авчихдаг юм байна гэвэл хэн ч манай улсад хөрөнгө

оруулахгүй. “Хан ресурс” зэрэг олон хөрөнгө оруулагчийн хувьцааг төрд хүчээр аваад авахгүй гэдэг байр сууриа илэрхийлсэн, тэрнийх нь дараа Хятадын болон Казахстаны компаниудтай хамт манай компани хувьцаа худалдаж авах өрсөлдөөнд оролцсон. Ер нь “Эрдэнэт”-ийн 49 хувийг тойрсон үйл явдал дээр заавал буруутан гаргаж ирэх гээд байгаа бол миний бодлоор тэр нь хувьцаагаа зарсан Оросын тал. Хүн өмчөө зарах, үгүй нь өөрийн л мэдэх хэрэг. Тэр байтугай, хэнд зарахаа өмчийн эзэн мэддэг. Энгийн амьдрал дээр ч ийм дүрэм үйлчилдэг. Хувьцаагаа зарлаа гэж оросуудыг буруутгавал бид л инээдтэй харагдана.

-Ер нь оросууд яагаад хувьцаагаа зарсан юм бол?
-Санхүүгийн зах зээл дээрх үйл явдлыг судалж байдаг хүний хувьд хэлэхэд, хоёр жилийн өмнөөс ОХУ-ыг тойрч дэлхий дахинд өрнөсөн үйл явц нөлөөлсөн байх. ОХУ-д хоёр жилийн өмнөөс геополитикийн бодлогоор гэх юм уу, Украйны асуудлаас болж янз бүрийн хориг тавигдаж эхэлсэн.

-Танай компанитай Хятад, Казахстаны компаниуд өрсөлдсөн гэлээ. Оросын тал танайхыг чухам ямар шалгуураар сонгосон юм бэ?

...Гэрээний 400 сая ам.долларын хувьд олон улсад “leveraged buy out” гэж нэрлэдэг, өөрийнхөөс гадна дутагдаж байгаа хөрөнгөө бусад санхүүгийн байгууллагаас зээлэх замаар санхүүжилт хийдэг. Энэ худалдан авалтыг хийхдээ бид тодорхой хэмжээний зөвлөх болон хуулийн компаниудыг авч ажиллуулсан. Нэгдүгээрт, “Ростех” бол цэргийн зориулалттай компани. Хоёрдугаарт, тодорхой хэмжээний санкттай...

“Эрдэнэт”-ийн 49 хувийг эзэмшиж байсан “Ростех” компанид хүртэл хориг тавьсан. Тодорхой түвшний албан тушаалтнууд болоод хувь хүмүүст мөн санктүүд тавигдсан. Гадаа явах эрхийг нь хаасан. Эдийн засгийн талаасаа бол 160 ам.доллар хүртэл үнэ нь өсөж байсан нефтийн ханш унаж, өнөөдөр л гэхэд 44-46 ам.доллартай тэнцэж байна. ОХУ-ын эдийн засгийн ихэнх орлого, татвар болон бусад төрлийн орлогыг бүрдүүлж байдаг түүхий эд нь нефть. Хоёр жилийн өмнө нэг ам.доллар 30 рубльтэй тэнцэж байсан бол өнөөдөр 65, бараг 70 хүрчиглээ. Ганцхан жилийн дотор рублийн ханш нь хэд дахин буурлаа. Энэ бүхнээс шууд хамааралтайгаар ОХУ-ын төсвийн алдагдал маш өндөр түвшинд хүрч байгаа. Төсвийн алдагдлаа нөхдөг ямар аргууд байдгийг та мэдэж буй байх. Хамгийн энгийн арга бол татвараа нэмэх замаар ард түмнээсээ мөнгө татах. Нөгөө арга нь төр өөрийн эзэмшиж

байгаа дотоод болон гадаад активуудаа зарах. Ер нь ганц “Эрдэнэт” биш, хөнгөн цагаан, нефть зэргээс авхуулаад нилээд активгаа зарж, төрийн ачааг хөнгөлөх шаардлага тулсан байх. Дараагийн шалтгаан нь “Эрдэнэт” үйлдвэр насжилтын хувьд хугацаан нь дуусгавар болж байгаа (технолги болон нөөцийн хувьд). “Эрдэнэт” үйлдвэрийн хувьд үүнээс цааш 15 жилийн хугацаанд хаалтын горимд шилжин ажиллах шаардлагатай байгаа.

-Танай компанитай Хятад, Казахстаны компаниуд өрсөлдсөн гэлээ. Оросын тал танайхыг чухам ямар шалгуураар сонгосон юм бэ?

маш их хүч, хөдөлмөрлөж байж “Эрдэнэт”-ийн 49 хувийг худалдаж авсан. Үүнийгээ Монголынхоо төлөө хийлээ гэж бодон хөөрч баярлаж байснаас бус, хэн нэгэн улс төрчийн карьер өгсөхийн төлөө ашиглах сэдэв болно гэж бодсонгүй. Урамгүй л байна, зүйрлэхэд олимпоос медал аваад ирэхэд “Чи шүүгчтэй хуйвалдаж авсан байх, медалийг чинь хураана” гэдэг улс өнөөдөр Хойд Солонгос л байх..

-“Эрдэнэт”-ийн 49 хувийг авсан 400 сая ам.доллар танай өөрийн хөрөнгө байсан уу?

-Гэрээний 400 сая ам.долларын хувьд олон улсад “leveraged buy out” гэж нэрлэдэг, өөрийнхөөс гадна дутагдаж байгаа хөрөнгөө бусад санхүүгийн байгууллагаас зээлэх замаар санхүүжилт хийдэг. Энэ худалдан авалтыг хийхдээ бид тодорхой хэмжээний зөвлөх болон хуулийн компаниудыг авч ажиллуулсан. Нэгдүгээрт, “Ростех” бол цэргийн зориулалттай компани. Хоёрдугаарт, тодорхой хэмжээний санкттай. Тэгэхээр гэрээ хэлцэхийг хэсээ өмнө бид АНУ-ын нэр хүнд бүхий, яг ийм төрлийн худалдан авалтад зөвлөгөө өгдөг нэр хүнд бүхий компани болох Skadden-аар хуулийн дүгнэлтээ гаргуулсан. Хоёрдугаарт, энэ гэрээ хэлцэл Монгол Улс болоод ОХУ-ын хууль, эрх зүйн хувьд хийж болох хэлцэл мөн үү, үгүй юү гэсэн асуулт байсан. Гуравдугаарт, суурь баримт маань ОХУ анх ЗХУ байхад БНМАУ-ын хооронд байгуулагдсан, дараа нь шинэчлэгдсэн. Энэ бүхэнд бид хуулийн дүгнэлт гаргуулахаар дэлхийд нэр хүндтэй мэргэшсэн компаниудыг ажиллуулсан. Нөгөө талаас, ОХУ-ын “Ростех” мөн Baker & McKenzie хэмээх, дэлхийд эхний тавд ордог Английн хуулийн фирмийг ажиллуулсан. Энэ хоёр компани мөн өөр өөрийн төлөөлөгчийг илгээж, хоёр орны хууль тогтоомжид үндэслэн дүгнэлт гаргуулсан. Үүнээс гадна ОХУ-ын Хууль зүйн яамны дүгнэлт ч байдаг. Эдгээр үйл явц өрнөсний дараа гэрээ хэлцэл явагдсан. Түүнээс биш, зарим хүний хэлж байгаа шиг ганц хоног, хэдхэн цагийн дотор шийдсэн асуудал биш.

-“Монголын зэс корпорац” Монголын компани уу. Үйл ажиллагаа явуулдаггүй, “Эрдэнэт”-ийн хувийг

авахын тулд гэнэт шинээр байгуулсан мэтээр бичээд байгаа?

-“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг худалдсан тухай шалгасан Засгийн газрын ажлын хэсэг өнгөрсөн долоо хоногт дүгнэлтээ танилцуулсан. Тэнд манай компанийг үндэсний гэдгийг онцолсон байгаа. Мөн УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж гуай хийсэн мэдээлэлдээ ч “Монголын зэс корпорац” гэж Монголын компани юм байна” гэж ярьсан байгаа. Албан ёсоор, хариуцлагатайгаар хэлэхэд, “Монголын зэс корпорац” 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани. Монголын өмчийг Монголдоо авчирсан компани. “Монголын зэс корпорац” бол тусгай зориулалтын компани. Урт удаан настай гэрээ хэлцэл дуусах шатандаа орсноор худалдан авах компанийг байгуулсан. Санхүүгийн хэллэгээр зөвхөн хувьцаа эзэмшихэд зориулан байгуулсан компанийг тусгай зориулалтын компани гэдэг. Дахин хэлэхэд, “Эрдэнэт” үйлдвэр дээр хувьчлал яваагүй, гадны эзэмшиж байсан хувийг худалдан авах процесс явагдсан.

Олон улсад ч, манайд ч тэр гэрээ хэлцэл бүгдээрээ л ийм төрлөөр хийгддэг. “Монголын зэс корпорац” яг л түүнтэй ижил. Энэ бол олон улсад тогтсон жишиг. Гэрээ хэлцэл амжилттай болсон нь энэ бүх асуултын хариулт болов уу. Компанийн өөрийн хөрөнгө санхүүгийн баримтаар 112 тэрбум төгрөг байгаа.

-Худалдаа хөгжлийн банкттай ямар холбоотой юм бэ?

-Санхүүгийн зөвлөх компаниар TDB-ийн охин компани TDB capital-ийг авч ажилласан. Яагаад гэвэл Монголд TDB capital шиг ийм туршлагатай компани үнэнийг хэлэхэд цөөхөн. Энэ компани маань Монгол Улсын Засгийн газарт зөвлөгөө, томоохон IPO хийчихсэн, IPO хийхэд андеррайтераар ажиллачихсан, санхүүжилт босгох тал дээр туршлагатай. Энэ талаасаа холбогдож байгаа. Тийм учраас Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон мэдээлэл хийсэн. Үүнийг олон нийт ХХБ-аа төлөөлж ярьж байна гэж ойлгосон байх. О.Орхон TDB capital гэж зөвлөх компаниа төлөөлж ярьсан.

-Цаашид ямар ажил

хийхээр төлөвлөж байна вэ?

-Нэн тэргүүнд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах менежмент хийх шаардлагатай. Жишээ нь, Оюутолгойн нэг тонн зэсийн өөрийн өртөг нь 2000 орчим доллар байгаа. Харин “Эрдэнэт” үйлдвэрийнх 4500 орчим доллар байна. Техник, технологийн хоцрогдол, хүдэр дэх зэсийн агуулга буурсан, уулын нөхцөл хүндэрсэн зэрэг яаралтай асуудлууд хүлээж байна.

Та бүхэн сонссон байх. MRI болон “Стандарт” банкны хэрэг гээд 100 гаруй сая ам.долларын шүүхийн процесс нь дараагийн толгой өвтгөсөн асуудал. Энэ мэт бараг 200 орчим сая ам.доллартай холбоотой асуудал олон улсын арбитрын шүүх дээр яригдаж байгаа.


Үүнээс гадна “Эрдэнэт” үйлдвэр 200-гаад сая долларын өр төлбөртэй, нөөц шавхагдаж байгаа гээд тоочоод байвал хүн баярлахаар зүйл ховор байна. Үүнийг хэлэхэд, сонгууль хурдан дуусах бидэнд ажилчдийнх боломж олгоосой гэж бодож байна. “Эрдэнэт” үйлдвэрт хувьчлал болоогүй худалдан авалт болсон. Төрийн 51 хувиас томилогдсон гүйцэтгэх захирал нь ажлаа хийж л байгаа шүү дээ. Олон улсын зохистой засаглалын стандартаар ТУЗ-ыг 49 хувийн төлөөлөл удирдах нь сайн засаглалд тооцогддог нь маргаангүй үнэн. Төрийн өмчит компанийн үр өгөөж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хүсэл үнэхээр байгаа бол компанийн менежментийг ч бидэнд өгөх нь буруу зүйл биш.

Өнгөрсөн УИХ-ын сонгуулийн үеэр төрийн мэдлийн 51 хувийн 49-г Хятадуудад зарлаа гэж баахан шуугисан, одоо орон нутгийн сонгуулийн үеэр төрийн мэдлийн 51 хувь алга боллоо гэж шуугьж байна. ТУЗ-ийг хүч түрэн булаан авч байгаа нь нэг хувьтай байх 49 хувьтай байх хооронд ямар ч ялгаагүй болгож, зах зээлийн зарчим эрүүлээр мөрдөгдөх боломжгүй болгож байгаа юм.

Гэхдээ энэ бүх асуудлуудаа бид хуулийн дагуу шийдүүлнэ. Үйлдвэрээ ашигтай ажиллуулж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэхэд ч анхаарна. Хийх хүн аргаа олодог, хийхгүй хүн шалтаг олодог гэдэг үг байдаг даа. Бидэнд эхэлсэн ажлаа дуусгахад сэтгэл дутахгүй ээ. Бодит мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа танай редакцийн хамт олонд баярлалаа.

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out



ИРГЭД НӨАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ АВАХЫГ ХҮСЧ БАЙНА ГЭВ

Н.БАТЗАЯА

НӨАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээр иргэд өөрсдийн худалдан авалт хийсэн бараа бүтээгдэхүүний баримтыг бүртгүүлж буцаан олголт авах боломжтой болсон билээ. Сүүлийн үед иргэдэд НӨАТ-ын буцаан олголтыг олгох эсэх нь тодорхой бус болсон. Тиймээс иргэдийн сэтгэгдлийг сонслоо.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



Б.Отгонсүх: Улсынхаа эдийн засгийг хөгжүүлэе гэвэл иргэддээ хоёр хувийн буцаан олголтыг нь өгчих хэрэгтэй

-Би НӨАТ-ын баримтын буцаан олголтоо авахыг хүсч байна. Нэгэнт л өгнө гэсэн юм чинь өгөх ёстой. Уг нь НӨАТ-ын баримтыг бүртгэх нь улс оронд хэрэгтэй. Энэхүү баримт гарч ирснээр аж ахуйн нэгжийн улсаас нуун дарагдуулдаг хөрөнгө нь ил

гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, татвараас зайлсхийдэг, татварын мэдүүлгээ худал өгдөг аж ахуйн нэгжийн орлогыг хянах боломжтой болсон. Иргэд ч НӨАТ-ын буцаан олголтоо авна гэж байгаа. Гэхдээ энэ талаараа улс орны эдийн засагт маш чухал үүрэгтэй. Хүмүүс сугалаанд хожно, буцаан олголтоо авна гээд баримтаа идэвхтэй бүртгүүлдэг болсон. Нэг жишээ ярь л даа. Хэрвээ улс эдийн засгаа хөгжүүлэе, татварын зөв бодлогоор явъя гэвэл ард иргэддээ буцаан олголтыг нь өгөх хэрэгтэй. Хэрвээ өгөхгүй байвал “За

баримтаа бүртгүүлээд яах юм. Угаасаа буцаан олголт өгдөггүй юм чинь цаг заваа гардаж энийг бүртгүүлээд яадаг юм” гээд иргэдийн итгэл алдарна. Ингээд иргэдийн итгэл алдарчигвал баримтаа бүртгүүлэхээ болино. Тэгэхээр арай гэж ил болгосон аж ахуйн нэгжийн орлогын мэдүүлэг нууцлагдах аюултай гэж би боддог. Иргэддээ хоёр хувийг нь өгчихөд улс ядуурахгүй л байх. Үнэн хэрэг дээрээ иргэдэд хоёр хувийг нь олгоно гэж байгаа ч улс НӨАТ-ын баримтаас 10 хувийн ашиг олж байгаа. Өмнө нь улсын төсөвт 10 сая ордог байсан бол одоо

20 сая болоод өсчихлөө. Энэ их татвар төвлөрүүлэлт иргэддээ хоёр хувиа өгөхгүй байснаас эргээд хумигдах магадлалтай. Манайхан эдийн засгаа хөгжүүлэе, цэцэглүүлэе гэж байгаа бол хоёр хувийн буцаан олголт дээр татгалзаад байх шаардлагагүй. Өгчих л ёстой юм. Би НӨАТ-ын сугалаанд идэвхтэй бүртгүүлдэг. Одоогийн байдлаар 74 мянган төгрөгийн буцаан олголт цугларсан. Хэрвээ буцаан олголт хийгдээд эхэлбэл тэр хэмжээний мөнгө авах юм. Би нэг хэсэг интернэттэй байранд байхдаа үргэлж бүртгүүлдэг байсан. Одоо харин

интернэтгүй газар байгаа. Тэгээд бүртгүүлж чадахгүй юм. Одоо ашлэйкшннийг нь утсан дээрээ татаж авъя гэж бодож байгаа. Интернэттэй, интернэтгүй орж болдог гэсэн. Би нэг удаа 20 мянган төгрөг хожсон. Түүнээс хойш урамшаад л идэвхтэй бүртгүүлдэг болсон. Сугалаанд хожчихоор хүн чинь урамшаад зах дээрээс ч юм авахаа больдог юм билээ. Аль болох л баримттай газраас авахыг хичээдэг. Баримтаа нэхээд авдаг. Одоо ихэнх газрууд ч хэлүүлэлтгүй өгдөг болсон байна билээ.



Ч.Ундармаа: Буцаан олголт авах гэж л баримтаа бүртгүүлдэг.

-НӨАТ-ын буцаан олголтоо авна гэж бодож байгаа. Тиймээс НӨАТ-ын баримтаа байнга бүртгүүлдэг. Одоогийн байдлаар би буцаан олголтоор 60 мянган төгрөг авах ёстой. Өдөрт нэг

талх авсан ч баримтаа заавал нэхэж авч, Ebarimt.mn сайтад бүртгүүлдэг. Хэрвээ би баримтаа бүртгүүлээд байвал нэгдүгээрт, НӨАТ-ынхаа буцаан олголтыг авна. Хоёрдугаарт, сугалаанд мөнгө хожих боломжтой. Тэгж л бодож баримтаа бүртгүүлдэг юм. Гэхдээ би НӨАТ-ын сугалаа эхэлснээс хойш нэг ч удаа астан болоогүй. Ер нь нэгэнт бид мөнгөөрөө худалдан авалт хийж байгаа. Тэр худалдан авалтынхаа тодорхой хэсгийг

улсад татвар хэлбэрээр өгдөг. Бид яг өөрсдөө очоод өгөхгүй ч бидний орлого оруулсан дэлгүүр, супермаркетууд улсад татвар төлдөг. Тэгэхээр хэн татварыг бүрдүүлж байна иргэд л бүрдүүлж байгаа биз дээ. Бид бүрдүүлсэн татварынхаа л тодорхой хэсгийг улсаас авна. Миний бодлоор ард иргэдийн амьдрал үнэхээр доройтсон. Урьд нь бид цалингаасаа өр зээлээ төлөөд, хоол хүнснийхээ зүйлийг цуглуулахад цаана нь унаандаа

зарцуулах, ойр зуур хэрэглэх хэмжээний мөнгө үлддэг л байсан. Одоо гэтэл өрнөөсөө илүү гарахгүй болчихлоо. Ард түмний амьдрал ийм л байна. Тиймээс иргэддээ НӨАТ-ын буцаан олголтыг өгчихөд яах вэ дээ. Бидний амьдралд л хэрэгтэй. Тэртээ тэргүй УИХ-ын гишүүд тийм айлчлал, тийм хүлээн авалт гээд хэрэгтэй, хэрэггүй зүйлд баахан л мөнгө үрдэг. Тэгж үр ашиггүй зүйлд бидний татварын мөнгийг зарцуулж, үрэн таран

хийж байхаар бидэнд эргүүлээд өгчих. Тэр мөнгөөрөө бид өрнөөсөө салахгүй юм аа гэхэд хоногийн хоолоо залуулья. Би бол НӨАТ-ын буцаан олголтоо авна. Авах ч гэж баримтаа өдөр, шөнөгүй бүртгүүлж байгаа. Тиймээс заавал авна. Авах ч ёстой юм.



Б.Төрбаяр: Буцаан олголтоо авахыг хүсч байна

НӨАТ-ын баримтаа бүртгүүлдэг. Буцаан олголтоо авна. Төр засаг анх буцаан олголт өгнө гэж л энэ

үйлчилгээг гаргаж ирсэн биз дээ. Амлалгандаа хүрч өгнө гэсэнээрээ өгөх хэрэгтэй. Сугалаанд хожно гэдэг ч дүүрсэн хэрэг болоогүй. Би нэг ч удаа астан болоогүй. Сонсож байхад хүмүүс астан боллоо л гэдэг. Надад л аз тохиолдсон юм алга. Хэд хоногийн өмнө их муухай зүйл боллоо. НӨАТ-ын баримтын ажилчин нь

10 гаруй удаа астан болсон байна билээ. Ард иргэддээ ингэж хуурч болохгүй. Бүгд л астан болохын тулд баримтаа бүртгүүлж байгаа. Хэн нь ч гэсэн астан болж, сугалаанаас мөнгө хожихыг л хүснэ. Хэрвээ ингэж муухай зан гаргах байсан юм бол анхнаасаа сугалаа явуулах хэрэггүй байсан юм. Сугалааг яах гэж

явуулдаг юм элдэв будилан, хээл хахуулгүй шударга үнэнээр байхын тулд л явуулдаг. Мэдээгээр тийм зүйл гарсан. Одоо харин иргэддээ буцаан олголтыг нь өгчих хэрэгтэй. Хэрвээ өгөхгүй байвал баримтаа бүртгүүлж, цаг заваа үрэх хэрэг алга. Тэрний оронд өөрт ашигтай зүйлийг хийсэн нь дээр. Нэгэнт

Монголын өнөөгийн нийгэм ямар байгаа билээ. Зарим байгууллага цалингаа ч цагт нь тавьж чадахгүй л байна. Энд хэн хохирч байгаа юм ард иргэд л хохирч байна. Ямар УИХ-ын гишүүд цалингаа авч чадахгүй, цалин нь буухгүй урда гэх биш. Тэгэхээр ядарсан ард түмэндээ өгчих хэрэгтэй. Би ийм бодолтой явдаг.



Т.Батчимэг: Азтан болоогүй ч НӨАТ-ын буцаан олголтоо авна гэж л бүртгүүлдэг

-Анх буцаан олголт өгнө л

гэсэн. Засаг төр солигдоод өгөхгүй болж байх шиг байна. Би баримтаа бүртгүүлж байгаа. Сугалаанд астан болчих болов уу, астан болоогүй ч НӨАТ-ын буцаан олголтоо авна гэж л бүртгүүлдэг. МАН бид энэ шийдвэрийг гаргаагүй гэж бодож байж магадгүй. Тэгээд буцаан

олголтыг олгохгүй гэсэн байх. Би хувьдаа Ардчилсан намын хэрэгжүүлж байсан ард иргэдийн амьдралд хэрэгтэй, үр өгөөжтэй олон ажлыг МАН зогсоолоо. Тэгэхээр ядаж НӨАТ-ын буцаан олголтыг хэвээр нь иргэддээ өгчихвөл нэг ч гэсэн зөв шийдвэртэй болох юм уу гэж боддог.

Би зүгээр л залуу хүнийхээ хувьд гарцыг л эрэлхийлж байгаа юм л даа. Энэ миний хувийн бодол. Мэдээж буцаан олголтыг авна гэвэл иргэд нийтгээрээ авахыг хүсч байгаа. Барааны үнэ нэмэгдсэн үед иргэдэд мөнгө дутна гэж байхгүй. Нэг талаар сугалаанд хожоогүй иргэддээ буцаан

олголтыг нь өгч урамшуулах хэрэгтэй. Энэ хууль гарснаар татвар төлөхөөс зайлсхийдэг хүмүүсийг мэдэх боломжтой болсон. Уг нь их зөв шийдвэр. Гэхдээ иргэддээ амласан зүйлээ биелүүлэхгүй бол муухай шүү дээ. Иргэд байхгүй бол энэ хууль хэрэгжихгүй.



Г.Батбаяр: Айл бүрт НӨАТ-ын баримт бүртгэлийг хариуцсан нэг хүн байдаг

-Би одоогийн байдлаар 187

мянган төгрөгийн буцаан олголттой болсон. Гэхдээ буцаан олголтыг жилийн эцсээр олгоно гэж байсан. Хүмүүст анхнаас нь баримтаа бүртгүүлбэл сугалаанд оролцож, астан болно, буцаан олголт авна гэдэг ойлголтыг өгсөн. Түүнээс болж иргэдэд баримтаа бүртгүүлэх ёстой

гэсэн сэтгэхүй суусан. Би гэхэд байнга баримтаа бүртгүүлдэг. Ер нь Монгол айл бүрт нэг орифлеймчин, архичин байдаг гэдэг шиг нэг НӨАТ-ын баримт бүртгүүлэгч байдаг болсон. Гэр бүлийн гишүүд нь баримтаа хариуцсан хүндээ авч ирж өгдөг. Тэр нь бүртгүүлдэг. Бидний амьдрал

тийм байна. Эндээс нэг зүйлийг ойлгох хэрэгтэй л дээ. Яагаад тэр хүмүүс тэгж баримт бүртгэдэг нэг хүн гаргаад тэр нь баримтаа идэвхтэй бүртгүүлээд байна вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Нэгдүгээрт, сугалаанд хожно гэсэн найдвар тэр хүмүүст байна. Хоёрдугаарт, буцаан олголт

авах боломжтой болохоор идэвхтэй байгаа юм. Манайд л гэхэд би бүртгүүлдэг. Хэрвээ баримтыг нь бүртгүүлэхээ мартчихвал эмзгэл хүртэнэ. Манай гэр бүл буцаан олголтоо авахыг хүсч байна.

ДУГААЫН СУРВАЛЖЛАГА



Б.ЛАВААХҮҮ
Н.БАТЗАЯА

Намрын шар навчис орчлон ертөнцийг чимж, хүүхэд хөгшид хааяахан гадаа нарлан суудаг намрын налгар өдрүүд ард хоцорч, нийслэлчүүд аль хэдийнэ өвөлдөө бэлтгэж эхэллээ. Их хотод өвөлжилтийн бэлтгэл ажил ундарч, хөлтэй болгон эрвийх, идэрвийхээрээ хичээж буй. Үүнтэй зэрэгцэн Налайхаас Улаанбаатарыг зорин тэв хийтэл ачсан нүүрсний машины цуваа олишфч, энэ жилийг өнөтэй давуулах нүүрсний үнэ ч тэнгэрт хадах нь бий. Товчхон хэлбэл, нүүрсний үнийн "сезон" эхэлчихсэн басхүү хялд үнээр боломжийн нүүрс авах гэсэн иргэд ихэссэн энэ цаг үед "Монголын мэдээ" сонин Налайхын нүүрсний уурхай, Цайз зах зэрэг нүүрс борлуулдаг томоохон цэгүүдээс энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

Уурхайн амнаас нэг ковш нүүрс 40-90 мянган төгрөгөөр гарч байгаа гэв

Хаа саагүй хог хийсч, энд тэндгүй дутуу ухсан том нүх, овоолж орхисон шороо, энхэл, донхол замын дунд нурж унасан байшингийн балгас харагдана. Хэн ч харсан энд хүн амьдардаг юм уу, амьдрах нь битгий хэл ажиллахад ч хэцүү харагдаж байна шүү дээ гэж уулга алдахаар энэ газар бол нийслэлийг 100 гаруй жилийн турш өвөлд гал алдуулалгүй хангаж ирсэн Налайхын уурхай. Цагтаа энэ газар мэргэжлийн их уурхай ажиллаж байсан ч 1990 онд дэлбэрэлт болж, түүнээс хойш нутгийн иргэд гар аргаар нүүрс олборлож, нийслэлчүүдийг түлээтэй золгуулсаар буй. Манай сурвалжлах хэсэг юун түрүүнд тэр хавдаа том гэгдэх уурхайг зорив. Биднийг очих үед ковшны моторын чанга дуу хангинаж, уурхайн ажиллагаа эд явагдаж байлаа. Уурхайн аман дээр ковш татах үүрэгтэй хоёр хүн зогсож харагдав. Тэдний хажууханд 30 гаруй насны гурван залуу гарч ирсэн нүүрсийг машинд ачих аж. Харин уурхайн амнаас зайдуухан портерууд цуван зогсжээ. Эд бол нүүрсний ченжүүд. Налайхын уурхайгаас нүүрс авч, хотод ирж борлуулдаг. Бид уурхайн даргатай уулзах гэсэн боловч тэрбээр бидэнд компанийн нэрээ нууцлахыг хүссэн юм.

Ингээд бид тус уурхайн бригадын дарга Н.Октябрийтай ярилцав. Тэрбээр "Өнгөрсөн жил ил уурхай их гарч байсан. Хөрс суултаар. Энэ жил ам гарсан байгаа. Үнэ нь өнгөрсөн жилийн энэ үеийнхтэй харьцуулбал нэмэгдсэн. Манай ковш нүүрс 90 мянган төгрөгийн үнэтэй. Нөг бүтэн талтай ачихад 120 мянган төгрөг болдог. Манай ковш том хэмжээтэй. Нэг ковш нүүрс

портер машины үндсэн тэвш л болдог юм. Уулын ажил болохоор өдөрт тэдэн машин гаргана гэж хэлж болдоггүй. Ойролцоогоор зарим үед хоногт 10-20 портер ачина. Тухайн үеийн байдлаасаа хамааран харилцан адилгүй. Ер нь энд хүн өөрийн биеэр ажиллаж байгаа учраас ачаалал ихтэй. Автомат ажиллагаанд шилжсэн хөгжсөн уурхай биш шүү дээ. Цохин, жоотуудана, хүрэдэнэ гээд ажил их болно. Манай уурхай залуучууд ихтэй. Хэрвээ үнэхээр нийгэмд ажил их байвал залуучууд заавал амиа золин энэ хүнд газар ажиллах шаардлага байхгүй. Ажил олдохгүй болохоор л энд ирж ажиллаж байгаа" гэв. Тус уурхай хоёр ээлжтэй бөгөөд 11-14 хүн ажилладаг гэнэ. Ингээд бид тус уурхайгаас холгүйхэн байрлах нэгэн аман дээр очив. Хуучин ил уурхайн олборлолт явагдаж байсан газарт хэд хэдэн ам байрлах аж. Уулыг эгц уруу ухааж, дунд нүүрс олборлож байлаа. Уулын ухсан хэмжээ бараг гурван давхар байшинтай зэрэгцэхээр өндөртэй юм. Энэ нь хуучин ил уурхайн ковш уурхайчид ярьж байв. Ил уурхай уулыг бүхэлд нь сэндийчиж ухдаг байна. Түүнээс болж бүхэл бүтэн уул дундуураа хуваагдаж, нэг талдаа гурван давхар барилгатай тэнцэхүйц хана үүссэн гэнэ. Тус уурхайд мөн л нүүрс ачих гэсэн машины дараалал үүсчээ. Тэгэхдээ портероос эхлээд том Зил-130 бүр камаз машин хүртэл дугаарлан зогсож харагдав. Эдгээр жолооч нар бүгд Улаанбаатар руу нүүрсээ оруулж зардаг байна. Тус уурхайд ковш нүүрс 40 мянган төгрөгийн үнэтэй. Тухайн уурхайн ковшны хэмжээнээс хамаарч нүүрсний үнэ харилцан адилгүй байдаг аж. Тодруулбал, том ковш нь 90-120 мянга, жижиг ковш нь 40-60 мянган төгрөгийн үнэтэй. Хоёрхон уурхайн аманд очиход ийм байна. Нийслэлчүүдийг өвөлд дулаанаар хангаж буй Налайхын уурхайн амнаас ченжүүдэд нүүрс

Нүүрсний үнэ нэмэгджээ

...Тус уурхайд мөн л нүүрс ачих гэсэн машины дараалал үүсчээ. Тэгэхдээ портероос эхлээд том Зил-130 бүр камаз машин хүртэл дугаарлан зогсож харагдав. Эдгээр жолооч нар бүгд Улаанбаатар руу нүүрсээ оруулж зардаг байна. Тус уурхайд ковш нүүрс 40 мянган төгрөгийн үнэтэй. Тухайн уурхайн ковшны хэмжээнээс хамаарч нүүрсний үнэ харилцан адилгүй байдаг аж...

40-120 мянган төгрөгийн үнэтэй борлуулж байгаа ажээ. Энэ жил бичин жилийн зуд болно гэсэн болоод ч тэр үү олон ам үйл ажиллагаагаа явуулж байгаа хэмээн уурхайчид ярьж байлаа. Жил бүрийн өдийд нүүрсний үнэ өсдөг талаар ч тэд онцолсон. Гэхдээ энэ жил өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад нүүрсний үнэ нэмэгдсэн хэмээн уурхайчид хэлж байлаа.

Жолооч нар 2-3 хоног хүлээн нүүрсээ ачуулж байна

Манай сурвалжлах хэсгийн анхаарлыг яах аргагүй нүүрс ачуулахаар дугаарлаж буй жолооч нар татсан юм. Биднийг очих үед зарим жолооч нар 2-3 хоног хүлэж байж нүүрсээ ачуулж



Гэрэл зургийг Т.АРТҮҮЖИН

байна хэмээн бухимдаж зогссон. Хар ноосон малгай, зузаан хар куртик өмссөн 50 гаруй насны эрэгтэйг Л.Мягмаржав гэдэг бөгөөд нүүрс ачуулахаар ирээд хоёр дахь хоногтойгоо золгож байгаа гэнэ. Энэ тухайгаа "Би энд хоёр хоног хүлээж байна. Уржигдар орой 05:00 цагийн үед /даваа гараг/ ирсэн. Бараг хоёр хонолоо. Нэг портер 160 мянган төгрөгийн нүүрс авдаг. Худалдан авалт маш муу байгаа. Бид 20-30 мянган төгрөг л нэмж



МЭДЭГДЭЛ

Монгол Улсын өрийн дотоодын нийт Мбүтээгдэхүүнд харьцуулсан хэмжээ их ч гэсэн харьцангуй тогтвортой явж иржээ. Тухайн үеийн эрх баригчид Чингис, Самурай бонд бусад өр, зээл үүсгэхийн тулд өрийн хэмжээг 2015 онд 58.3 хувь болгоод 2016 онд 55 хувь, 2017 онд 50 хувь зэргээр жил бүр шатлан бууруулж, 2018 онд буцаад 40 хувьд хүргэхээр хуульчилсан байна. Гэвч 2016 оны сонгуулийн үр дүнд гарч ирсэн шинэ эрх баригчид төсвийн тодотголын төсөлдөө өрийн таазын хэмжээг 55 хувь байх ёстойг 88 хувьд хүргэхээр хууль зөрчин төлөвлөсөн нь үндсэндээ улс орны амьдралыг зөвхөн өр, зээлээр санхүүжүүлж, улам ихээр хэзээ ч төлж чадахгүй өр ширэнд унагахыг зорьж байна.

Ийнхүү шинээр өр зээл үүсгэх үндэслэлээ өөр арга үлдээгүй гэж тайлбарлан Олон улсын валютын сангийн Стэнд-бай хатуу нөхцөлтэй зээлийн хөтөлбөрт хамрагдан улсын эдийн засгийн бодлогыг гадны бүрэн хяналтаар явуулах, эсвэл БНХАУ-аас хөнгөлөлттэй зээл авна гэж хоёулаа улс орны хувьд аюултай хувилбараас сонгохоор тулгаж байна. Хэрэв Хятад улсаас хоёр тэрбум

ам.доллартай тэнцэх юанийн зээл авахад хүрвэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-ийг ноцтой зөрчихөд хүрч бусад улсын гашуун туршлагыг давтаж болзошгүй байдал харагдаж байна. Тухайн улсыг эхлээд их хэмжээний өрөнд оруулаад буцаад өрийг нь төлүүлэх замаар удирддаг эсвэл бүүр газар нутгийг учир газар нутгийнхаа зарим хэсгийг өгч Нийслэл Душанбегийн эрх баригчид стратегийн чухал ач холбогдолтой Горно-Бадахшаны 1500 гаруй км хавтгай дөрвөлжин газар нутгийг Бээжингийн захиргаанд шилжүүлсэн юм.

Иймд сонгуулийн амлалтаа биелүүлж, улс орны өр зээлийг хуулийн хүрээнд тогтоон барьж, эдийн засгийн сэргээх бодлогыг нэмж өр зээл үүсгэх, өрийг өрөөр дарах, гадны зүгээс хамааралтай болох, эсвэл бүүр газар нутгаа алдах эрсдэлтэйгээр биш өөр эрүүл саруул аргаар Монгол Улсын ирээдүй, Үндэсний аюулгүй байдлыг харгалзан үзэж, төсвийн тодотголын 88 хувийн өрийн төлөвлөгөөгөө нэн даруй татан авахыг шаардаж байна!

ДАРХАН МОНГОЛ НЭГДЭЛ
Улаанбаатар 2016.10.05

ДУГААЫН СУРВАЛЖЛАГА

зардаг. Тэгэхээс өөр аргагүй. Бид чинь өөрсдөө амьдралтай хүмүүс. Нүүрсийг чинь зүгээр нэг ачиж, аваачаад зарчихгүй шүү дээ. Машинаар тээвэрлэх хэрэгтэй. Машины ашиглахын тулд шатахуун хэрэгтэй. Шатахуунаа бас худалдаж авна. Цайз зах дээр очоод нүүрсээ шууд зарчихгүй. Заримдаа авах хүн байхгүй бол хонох шаардлага гарна. Хэрвээ хоновол хоол авч идэх хэрэгтэй болно. Энэ мэтчилэн олон зүйл бий. Бүх урсгал зардлынхаа мөнгийг оруулаад 20-30 мянган төгрөг нэмж зардаг. Хүмүүс үүнийг ойлгох ёстой. Бид чинь өдөр шөнөгүй дугаарлаад, заримдаа хоолтой, хоолгүй, нойртой, нойргүй л явдаг улс. Тэгж байж л нүүрсээ ачуулж байгаа юм чинь” хэмээн бухимдсан. Түүний бухимдаж арга ч үгүй биз. Өдөр, шөнөгүй дугаарлаж, заримдаа уурхай дээр хонож байж нүүрсээ ачуулдаг юм чинь. Уурхай дээр хонох айл байх биш. Хэрвээ нүүрс нь шөнийн 2-3 цаг гарна гэвэл тэр цагт нь гозойж байх учиртай гэнэ. Манай сурвалжлах хэсгийн очсон уурхай болгон дээр жолооч нар дугаарлаж басхүү бухимдалтай зогсож харгадсан. Тэдний нэг бол “Би гуравхан ковш нүүрс ачих гэж хоёр хоног хүлээж байна. Одоо хот руу нүүрс ачаад орвол 96 мянган төгрөгөөр торгодог болсон. Баянзүрхийн товчоон дээр байнгын цагдаа эргүүлд гардаг. Биднийг явуулахгүй шүү дээ. Би нэг ковш нүүрсийг 45 мянган төгрөгөөр ачуулдаг. Өдөр ирэх тусам нүүрсний үнэ нэмэгдэнэ. Одоо миний ачуулж байгаа уурхайн ковш нүүрс 50 мянган төгрөг болох гээд байна.

нүүрсний “Цайз” зах байв. Тус захын орох хаалга болон замын эсрэгталд төрөл бүрийн хэмжээтэй шуудайнд хийсэн нүүрс, модыг эгнүүлэн тавьж хажууд нь өвлийн зузаан куртик дотуураа юдэнтэй цамцыг давхарлан өмссөн хүмүүс зогсч харгадана. Тэдний зарж буй нүүрс нь том шар шуудайтай, дунд цайвар шуудайтай, жижиг шар шуудайтай гэх мэт төрөлтэй байх бөгөөд тус тусдаа өөр үнэтэй. Нөгөөтэйгүүр, мод нь том болон жижиг гэсэн төрлөөр

модонд зориулагддаг бол үлдсэн захын нүүрс нь “Шуудайны мод” байдаг гэнэ. “Шуудайны мод” гэдэг нь хувь хүмүүсийн худалдаалдаг түлээний мод гэсэн үг аж. Ямартай ч, модны нийлүүлэлт багасантай холбогдуулан шуудай модны үнэ өсчээ. Үнэхээр ч захын хашаа эл хуль болсон харгадана билээ.

жижиглэнгийн худалдаачдаар дамжин иргэдийн гарч бүр гурав нугаран хүрдэг ажээ.

Шуудай 150-300 төгрөгний үнэтэй

Жил бүрийн хүйтний эрч чангарсан энэ үед айл өрхүүд өвөлдөө бэлтгэн түлээ нүүрсээ базааж эхэлдэг. Гэтэл хэмжээ нь улам бүр жижгэрсээр байдаг зүйл бол нүүрс, модны шуудай байдаг.

хунар нь тортог болсон хоёр залуу газарт асгасан нүүрсийг шуудайлж зогслоо. Тэд Налайхын өндөрлөгөөтэй нэг портер нүүрсийг 250 мянган төгрөгөөр худалдаж авч, шуудайлж буй нь энэ гэнэ. Тэдний хажууд дунд зэргийн ногоон шуудайтай нүүрснүүд эгнэх бөгөөд сонич зандаа хөтлөгдөн нэг портер нүүрс хэд орчим шуудай болдгийг сонирхлоо. Дунд зэргийн шуудайгаар тооцвол нэг портер нүүрс 170 гаруй шуудай болдог

Гэр хороололд шуудай модны үнэ 500 төгрөгөөр нэмэгдсэн байв

“Цайз” захыг орхиж, дараагийн зорьсон газар бол бидний нэрлэж заншсанаар “Долоон буудал” байв. Мод, нүүрсний зах гэгддэг “Цайз” захын үнээс гэр хороололд худалдаалагдаж буй нүүрс модны үнэ хэр зөрүүтэй байдгийг



ЦААШИД Ч ӨСНӨ

Нүүрсээ үнэтэй гаргаж байгаа өөр уурхай бий. Нүүрсний сезон эхлэх үеэр үнэтэй байдаг. Тэгээд ч борлуулалт их муу байгаа. Ард иргэд мөнгөгүй болохоороо нүүрсээ ч худалдаж авахгүй байна. Би нүүрсээ эндээс 170 мянган төгрөгөөр асуулаад 200 мянган төгрөгөөр борлуулдаг. Тэгж их нэмж зардаггүй” гэсэн юм. Жолооч нар урсгал зардлаа оролцуулан 20-30 мянган төгрөг нэмж нүүрсээ борлуулж байгаа гэдгээ ч нуусангүй.

Нүүрсний үнэ цаашид өснө

Улаанбаатарчууд шинэ жил хүртэл хямд үнээр нүүрс худалдаж авч чадахгүй хэмээн уурхайчид болон жолооч нар хэлж байлаа. Учир нь 9-12 сар хүртэл иргэд өвөлдөө бэлтгэж, нүүрс худалдан авах нь ихэсдэг аж. Түүнийг дагаад нүүрсний үнэ ханш нэмэгдэж, тэр дундаа Налайхын нүүрс эрэлт хэрэгцээтэй байдаг. Харин шинэ жилийн дараагаас нүүрсний үнэ буурч эхэлдэг гэнэ. Тэгвэл дөнгөж намрын сүүл сар гарахтай зэрэгцээд л нүүрсний үнэ нэмэгдээд эхэлжээ. Тэгэхдээ өнгөрсөн жилийнхээсээ 20-30 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өнгөрсөн жил ил уурхайн нэрийг дээр Налайхын ихэнх уурхайг хаасан нь үнэ нь буурахад нөлөөлжээ. Харин энэ жил нөхцөл байдал эсрэгээрээ эргэж, олон нүүрсний ам нээгдсэн байна. Түүнээс болж нүүрс ачих гэсэн жолооч нар ч олширч, уурхайчид үнэ нэмэх болсон аж. Цаашид ч нүүрсний үнэ нэмэгдэх хандлагатай байна хэмээн уурхайчид хэлж байв. Нүүрсний үнэ нэмэгдэх болсон бас нэгэн шалтгаан бий. Энэ жил бичин жилийн зуд тохионо гээд хот, хөдөөгүй эмээн өвөлдөө бэлтгэж байгаа нь нууц биш. Иргэдийн энэхүү эрэлт хэрэгцээ нүүрсний үнэ нэмэгдэх нэгэн шалтгаан болсон гэхэд хилсдэхгүй. Ямартай ч Налайхын хоёр уурхайгаар ороход л нөхцөл байдал нийм байлаа. Нүүрсний үнэ цаашид одоо байгаагаасаа дахин 5-10 хувиар өсөх хандлагатай нь сурвалжлагын явцад ажиглагдаж байсан юм.

Модны нийлүүлэлт багасчээ

Бидний дараагийн өртөө мод,



худалдаалагдах аж. Захын том хашааны үүдээр ормогц энд тэндгүй л хөрөө раамны мод зүсэх дуу сонсогдож, хэн болох нь танигдахгүй болтлоо модны үртэс болсон залуус шалмаг гэгч нь модоо зүсэн. Харин цааш явбал хэсэг хүмүүс түлээний мод хөрөөдөн хагалж шуудайлж байлаа. Өглөө эрт захыг зорьж ирсэн болохоор ч тэрүү хөл хөдөлгөөн бага байв. Хаа нэгтээ хүмүүс ирж байгаа харгахад хэдий ч, захын гол хаалганы ойролцоох зам дагуу түлээ зарж буй хувь хүмүүсээс нэг, хоёр шуудайгаар нь худалдан аваад хөдөлж байсан юм. Бид модны үнэ ямар байгааг сонирхохоор мод хагалан шуудайлж байсан хэсэг хүмүүс дээр очлоо. Гадаа сэрүүхэн байсан ч, зузаан цамцтайгаа зогсоо зайгүй тонгочин, магнайд нь хөлс булзайх хоёр эмэгтэй, нэг эрэгтэй нийт гурван хүн тэнд байв. Тэд модны үнийн талаар сайн мэдэхгүй, зүгээр л мод хагалан, шуудайлах ажил хийдэг гэдгээ учирлаж байсан ч, “10 гаруй хоногийн өмнө том шуудайтай мод 3000 төгрөг байсан. Гэтэл одоо 4000 болчихсон” гэв. Тэдний тайлбарлаж буйгаар мод тун ховордсон гэнэ. Хааяа портер мод зах дээр ирэх бөгөөд худалдаачид нэг нэгээсээ өрсөн худалдаж аваад л дуусчихдаг гэлээ. Өнгөрсөн жилүүдэд мод тун элбэг байсан аж. Захад ирсэн модны ихэнх нь байшин барилгын

Тэндээс гарч захын нүүрс зардаг хэсгийг чиглэн явах замдаа шуудайтай нүүрс зарж зогссон ахимаг насны эгчтэй нь уулзлаа. Хэвлэлээс яваа гэх ганц үгийг сонсмогцоо тэрхүү эмэгтэйн царай нь хувьсхийж, “Уурхайн аман дээр байгаа дарга нараасаа очиж яриа ав. Нүүрсний ченжүүд үнийг тогтоож байхад бид мэтгийн ядарсан ард иргэдээс юм асуугаад яах нь вэ. Портер нүүрс энд ирээд 260-300 мянган төгрөг болж байна. Өнгөрсөн жил арай ч нийм байгаагүй. Үүнийг жижиг шар шуудайтай нүүрсээ дагаад шуудайлсан нүүрсний үнэ ч өсчихдөг байхгүй юу. Уурхайн хүмүүсээсээ яриа ав” гэж хэлээд халгаасангүй. Тус эмэгтэй жижиг шар шуудайтай нүүрсээ 2000, том шуудайтай нүүрсээ 3500, жижиг шуудайтай модыг 1500, том шуудайтай модоо 4000 төгрөгөөр худалдаалж байлаа. Түүний хэлснээр, өнгөрсөн жил шуудайлсан нүүрс энэ жилийнхээс 500 төгрөгөөр хямд байсан гэнэ. “Цайз” зах орчмын зам дагуу түлээ худалдаалж буй иргэд мөн л ийм үнээр худалдаа хийж байсныг энд дурьдах хэрэгтэй болов уу. Захад портероор нүүрс зарж буй хэн ч байсангүй. Гагцхүү хүмүүс нь Налайхын нүүрс 260-280 мянга, Багануурын нүүрс арай хямд 250 орчим мянга байгаа хэмээн ярьж байв. Уурхайн амнаас 120 орчим мянган төгрөгөөр ченжүүдэд хүрч буй нүүрс, нэг нугалагдан “Цайз” захад хүрдэг бол цааш

Уртаасаа нэг их хасагдахгүй хэрнээ жил ирэх бүр нарийссаар байдаг гэдэгтэй хэн ч маргахгүй биз. Өнгөрсөн жил төслийн зуухаа гурав галлахчид байсан жижиг шар шуудайтай нүүрсээр өнөө жил хоёр галладаг болсон байх хэмжээний. Модны уут ч ялгаагүй. Үнэндээ шуудай гэж нэрлэгдэх хэдий ч, 100 төгрөгний торыг хоёр хуваасантай тэнцэх хэмжээний уут бүхий нүүрсийг 2000 төгрөгөөр авч, өрх гэрээ дулаацуулж байна. Эдгээр шуудайнуудыг зах дээр худалдаалдаг бөгөөд хэмжээнээс хамаараад үнэ нь өөр өөр аж. “Цайз” захын хаалганы ойролцоох лангуунд төрөл бүрийн шуудайнууд зарж байх бөгөөд мод, нүүрсний том шуудай 220, харин жижиг шуудай нь 150 төгрөг гэж байна. Харин энэ үнэ мод хагалан шуудайлж буй таван алхмын цаана очихдоо 30 төгрөгөөр нэмэгддэг юм билээ. Мод хөрөөдөн хагалж, шуудайлах хэсэгт мөн шуудай худалдаалах бөгөөд тэнд том шуудай 300 төгрөгний үнэтэй байсан юм. Худалдаачдаас чухам ямар учраас шуудайны хэмжээ жижигрээд байгааг асуухад, үнэндээ хариулах хүн олдсонгүй.

Нэг портер нүүрс 170 шуудай болдог гэнэ

Цааш явж нүүрс зардаг хэсэгт очиход нүүр, гар, хувцас

сонирхох үүднээс энэ зүгт хөдөлсөн юм. Гэхдээ нүүрсний үнэ бараг адилхан байсан юм. Том шуудайтай нүүрс нь 3500 төгрөг бол жижиг шар шуудайтай нүүрс нь 2000 төгрөг гэж байлаа. Харин шуудай модны үнэ 500 төгрөгөөр нэмэгдэжээ. Шуудай нүүрс, модыг өрж, зарж зогссон эмэгтэйн хувьд жижиг шуудайтай модоо 1500 төгрөг, томыг нь 4500 төгрөг гэж байв. Түүнчлэн, 32-ын тойрог орчимд мод, нүүрсний үнэ хэр байгааг сонирхон хөдөллөө. Тэнд ч гэсэн мод, нүүрсний үнэ дээрхтэй ижил байв. Бид нүүрс, мод худалдаалан зогссон ахимаг насны Цгэгчтэй уулзаж, нүүрсний үнэ ханшийн талаар асуухад, “Портерны тэвштэйгээ чацуулж ачсан Налайхын нүүрс 200 мянга төгрөг байгаа. Үндсэн тэвш дээрээ жаахан овоолж ачсан нь 280 мянга болж байна. Өндөрлөж ачсан нь 300 мянган төгрөгөөр зарагдаж байна. Өнгөрсөн жилийнхээс нэлээд өссөн. Налайхдаа ковш нүүрсний үнэ 45-50 мянга байгаа юм. Ноднин жил 30 мянга байсан шүү дээ. Үүнийг дагаад шуудайлсан нүүрсний үнэ өссөн. Жижиг шуудайтай нүүрс өнгөрсөн жил 1500 байсан бол энэ жил 2000 болсон байгаа” хэмээн ярилаа. Манай сурвалжлах баг очсон зах, түлээ нүүрс худалдаалах цэгт очих бүртгээ утаагүй шахмал түлш зарж буй эсэхийг лавлаж явсан юм. Гэвч нэг ч газар уг түлш байсангүй.

Эцэст нь тэмдэглэхэд, нийслэлийн гэр хорооллын иргэд идэх мах, түлэх нүүрсээ хэд дахин нугарсан үнээр авч хэрэглэдэг жишиг тогтоод уджээ. Малын мах гэхэд хэдэн ченжийн гар дамжин үнэ нь нэмэгдсээр хэрэглэгчийн гарт очдог бол нүүрс ч мөн адил энэ мэт худалдаачдын гараас гар дамжин ханш нь өссөөр гэр хорооллын иргэдэд хүрч байна. Цаашид хүйтний эрч өнөөдрийнхөөс чангарах үед өнөөх нүүрсний үнэ дахин өсдөг бичигдээгүй хууль үйлчлэх нь гарцаагүй. Тэр үед нийслэлийн иргэдийн ихэнхийг эзлэх гэр хорооллын иргэд өвлийг гал алдахгүй давахын тулд хаягдал дутуй түлэхээс өөр аргагүйд хүрэх вий. Утаагүй зуухны төсөл бүрэн зогсч, захууд болон түлээ худалдаалах цэгт шахмал түлш борлуулах нэг ч цэг байхгүй байхад, энэ өвөл саарал утаанаас сална гэж сэрүүн зүүдлэх хэрэгтгүй бололтой.

Нөлөөт толь



Сумын инфляци буурцуулж,

ХӨДӨӨГ СИНГАПУР ШИГ ХӨГЖҮҮЛНЭ

Н.БОЛД

Өнгүүлийн үерэлдэв амлалт өгөхийг алийг тэр гэхэв. Тэр дундаа УИХ-ын сонгуулиар. Таныг нэг өдөр хаан болгоё гэж өнөө шоу шүүгээд байдаг хип хоп үглэдэг хүүд очиж амлалт өгсөн л гээгүй байгаа даа, арай. Манай ард түмэн ч амлалтад итгэмтгий, гэнэн цагаан, уужуухан сэтгэлтэй хүмүүс юм. Түүнийг улстөрчид нь яасан сайхан ашигладаг юм.

Эмэгтэй хүн төрж, эрэгтэй хүн шаргаж хаширдаггүй юм гэнэ билээ. Харин манай иргэд бол амлалтад хуургаж ханахгүй шинжтэй. Хэзээ ч энэ энэрэнгүй нинжин сэтгэлээ гээж, элдэв амлалтыг нь эргэцүүлдэг болох юм бүү мэд. Сүүлийн үед орон нутгийн сонгуульд өрсөлдөж байгаа нөхдүүд өнөөх гоё амлалт өгдөг аргыг хэрэглэж эхэллээ. Дорнод аймгийн Хэрлэн суманд нэр дэвшиж байгаа нэг залуу

"Дорнод нутгаа Сингапур шиг хөгжүүлнэ. Ард иргэдээ Саудын Араб шиг баяжуулна" гэсэн амлалт өгч. Нэг аймгийг тасдаж аваад, улсаас илүү гаргаж хөгжүүлээд, иргэдийг Арабын Шахууд шиг баяжуулна гэж бодохоор энэ нөхөр ой тойнд багтамгүй их хөрөнгө мөнгөтэй бололтой юм. Ямар ч байсан Дорнодыг бол Сингапур шиг хөгжүүлээд, цоо шинэ хот болгоод, улс дотор улс байгуулчих хэмжээний

хөрөнгө түүнд байна гэсэн үг. Тийм болохоор манай улстөрчид гадаадаас мөнгө хайж явахаар өөрийнхөө зарим нэг авдрыг уудлаад, хэдэн төгрөг авчихмаар юм. Бас нэг нөхөр сумын инфляцийг бууруулахаа амласан байна билээ. Хэрэндээ л хөөрхөн эдийн засгийн мэдлэг үнэртүүлсэн нэр дэвшигч бололтой юм. Бодвол ялж гараад, сумын Засаг дарга болоод, дараа нь инфляцитай тэмцэх юм

уу даа. Уг нь одоогоор манай улсад бууруулаад байх инфляци байхгүй. Буурдгаа буураад, бүр дифляци болчихоод, эдийн засаг өсөлт нь зогсох өвчинд нэрвэгдчихээд байгаа. Ийм үед инфляци бууруулахын төлөө ажиллахаар ярьж байгааг бодоход тэр сум нь Монгол Улсаас эдийн засгийн хувьд ангид бололтой юм. Тэгээд сумынх нь инфляци өсөөд, иргэдийнх нь амьдрал хэцүүдээд байгаа юмдаг уу даа. Хэрвээ тийм бол бууруулахын төлөө зүтгэлгүй л яахав. Буруутгаад байх арга байхгүй. Энэ мэт том том зорилготой хүмүүс орон нутгийг хөгжүүлэхийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэхээр гарааны шугам дээр зогсч байна. Гол нь иргэдийн итгэл л хэрэгтэй гэж байгаа. Ер нь бол том юм амласан хүн талыг нь хийчих магадлагтай. МАН л гэхэд хүүхдийн мөнгийг бүгдэд нь өгнө л гэсэн. Одоо 60 хувьд нь ямар ч байсан өгч л

Улаанбаатарт:

Weather forecast for Ulaanbaatar. Includes icons for sun and clouds, and text: Маргааш Өдөр 13 Шөнө -1; Нөгөөдөр Өдөр 15 Шөнө 1.

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Нэг цагаан мэнгэтэй Улаагчин туулай өдөр. Буд гараг

Үс засуулбал: Эрхтэн хурц болно Наран ургах, шингэх: 07:11 - 18:21



Өдрийн өнгө: Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба логой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтаг хандаж, биеэ энхрийлүүцтэй. Эл өдөр эл, элнэгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн талифыг сэргээх, угаал үйлдэх, тал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүлүүнтэй уулзахад сайн. Газар хаалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, баф, туулай, морь, хонь, тахиаболло. Хол газар яваар одогсод зүүн хойш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

ДУУЛГАХ СОНИН

Эмэгтэй реппэр Mrs.M "секс симбол"-ын охин байжээ

"Шинэ үе" хамтлагаасаа гарч, "U Film"-ийг байгуулан, "Ганц бие бүсгүйчүүд 1, 2", "Тютю" зэрэг уран сайхны киног бүтээгээд байгаа жүжигчин, найруулагч Г.Ундармаа дараагийн уран бүтээлдээ орсон байна. Тэрбээр одоогоор "Х-Түг" продакшнд харьяалагдаж, хошин урлагтаа эргэж ирээд байгаа ч кино уран бүтээлээ орхигдуулаагүйгээр барахгүй дөрөв дэх киноныхоо гол дүрд уран бүтээлээсээ завсарлага аваад байгаа авьяаслаг жүжигчдийн нэг О.Энхтуулыг урьж, тоглуулжээ. Жүжигчин О.Энхтуул түүний урилгыг хүлээн авч, Герман улсаас хоёр сарын өмнө ирчихээд тун удахгүй буцах гэж байгаа аж. Найман жилийн турш эх орондоо ирээгүй жүжигчин бүсгүйг хэвлэлийнхэн онцолсоор байна. Түүнчлэн О.Энхтуул буюу "секс симбол"-ын нэгэн

нууц задарсан юм. Энэ бол түүний охин эмэгтэй реппэр Mrs.M юм. Хэзээ ч нүдээ харуулдаггүй, нууцлаг энэ эмэгтэйд дуучин Э.Энхзолгой хамтран дуулж, дүржүүлсэн "Single Ladies-2" киноны дуугаар хүмүүс сайн мэдэх биз ээ. Mrs.M хэмээх нууцлаг нэгэн эмэгтэй реппер өөрийнхөө хүслээр бүхнийг хийхийг эрмэлздэг бөгөөд саяхан цомгоо өлгийдөн авсан тухай түүний ээж, О.Энхтуул хэлсэн юм. Ямартай ч ээжийнхээ урлагийн замналыг охин нь үргэлжлүүлэхдээ тайз, дэлгэцийн урлагаар биш харин Монголын хип хоп ертөнцөд цахуур хагалах бололтойдог шүү.



Рио-2016 наадмын боксын тэмцээнийг шүүсэн бүх шүүгчийн эрхийг хаслаа

Бразилын Рио хотноо зуны Олимпын 31 дүгээр наадам болсон билээ. Тэгвэл энэ удаагийн Олимпын наадмын боксын төрөлд маш их будилаан гарч, ялалтаа луйвардуулсан тамирчид аргаа барахдаа шүүгчид руу салаавч хүртэл гаргаж үзсэн. Харин Олон улсын сонирхогчдын

боксын холбоо удтал хуралдсаны эцэст Олимпын наадмыг шүүсэн бүх шүүгчийн эрхийг хасах шийдвэр гаргажээ. Энэ удаагийн Олимпын наадмын боксын төрлийг 36 шүүгч дэнсэлсэн юм. Тэгвэл Олон улсын сонирхогчдын боксын холбоо тэдгээр бүх шүүгчийн

эрхийг хаслаа. Риогийн Олимпын наадамд манайхаас зургаан тамирчин оролцож, нэг хүрэл медаль хүртсэн юм. ОУХМ Д.Отгондалагийн хувьд мөнгөн медалийн төлөөх тулаанд бас л эргэлзээтэй шүүлтийн хохирогч болсон билээ.



Darkhaa Khuyag

Миний иргэний үнэмлэх дээр нэг дэлбэрчихсэн зураг байдаг юм. Өнгөрсөн жил иргэний үнэмлэхээ сунгуулахаар хороон дээрээ очоод юу юу бүрдүүлэх ёстой вэ гэдгээ асуутал хоёр хувь цээж зураг бас бус зүйл хэрэгтэй гэлээ. Хамгийн гоё дээрээ тавиад зургаа авхуулж, бүр зурагчнаар нь давхар янзлуулан маргааш өглөө нь босонгуутаа л дүүрэг дээрээ яваад очлоо. Гэтэд "Наад зураг чинь хэрэггүй, цаад ханандаа очоод зогс" гэдэг юм даа. Үсээ засуулаагүйн дээр нүднийхээ нуухыг ч гүйцэд аваагүй үнэндээ аймшгийн царай зүстэй байсан хэрэг л дээ. Тэгээд удаан дугаарлаж зогссон болохоор дүүрсэн хэрэг гээд зургаа авхуултал, хүүхэд айхаар зураг гарч билээ. Ядаж байхад тэр чигт нь иргэний үнэмлэх дээр хэвлэчихсэн. Одоо үнэмлэхний зургаа харахаар хэд хоног уугаад, долоон буудал чирүүлчихсэн юм шиг харагдаад нүд хальтраад байдаг юм. 2035 он хүртэл хол байна даа. Ха ха ха.

Бидэнд тохиолдсон



Movie listings for TENGIS KINO THEATRE. Includes movie titles like 'ИТГЭЛ', 'ЕРӨВТАС', 'ХАРААЛ', and showtimes for various screenings.